

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-32

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 3-32

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
09 дүгээр сарын 14-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 14 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Уянгахишиг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Бямбасүрэн, Ж.Золжаргал;

Тасалсан: Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Э.Одбаяр, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, мөн банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Н.Ургамалсүвд, Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер С.Нацагдорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Үнэт цаасны газрын захирал Б.Дөлгөөн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Амартүвшин, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сумъяа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтүвшин, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх, Стандарт, хэмжил зүйн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Мягмарцэрэн, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх

захирал Б.Даваадалай, мөн компанийн Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Зоригтбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Эрдэнэсамбуу, референт Б.Алтан, Х.Шижирмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Уянга, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Б.Мөнхсоёл, М.Мандхай, Ц.Баатархүү, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтүвшин, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх, Стандарт, хэмжил зүйн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Мягмарцэрэн, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэбат, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Уг асуудлыг 13 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 47 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 78.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 14 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Заяабал: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.1 хувь бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааныг нээе.

Өнөөдрийн хуралдаанд ирсэн Улсын Их Хурал /УИХ/-ынхаа гишүүдийг танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Пүрэвийн Батчимэг гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн 17 гишүүн ирцэд орсон байна. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Нэг асуудал байгаа. Саналтай гишүүд байхгүй байна, хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд. Ажлын хэсэг танилцуулаад явах уу? Шууд эхлээд танилцуулгаа хийхчээд дараа нь танилцуулах уу? Тэгье. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Сангийн сайд Загджавын Мэндсайхан сайд оролцож байна. Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Даваасүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Наранцогт, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Ургамалсүвд, Монголбанкны Санхүү зах зээл, валютын газрын захирал Мөнхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Энхболд, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх

аудитор Баттуяа, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Нацагдорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат, Үндэсний статистикийн хорооны /УСХ/ дарга Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны /СЗХ/ Үнэт цаасны газрын захирал Дөлгөөн, Сангийн яамны Өрийн удирдлагын газрын дарга Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Амартүвшин, Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын, Төрийн нарийн бичгийн дарга нь ирсэн байна, Зам, тээврийн яамны ТНБД Баярмагнай, Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сумъяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Болорсүх, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмарнаран, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Энхтүвшин, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн, Чингис хаан баялгийн сан нэгдэл компанийн Санхүүгийн бодлогын газрын дарга Зоригтбат, Чингис хаан баялгийн сан нэгдэл компанийн гүйцэтгэх захирал Даваадалай нарын ажлын хэсгийн хуралдаанд оролцох албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гэж заасан. Ингээд Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн талаарх асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Ирцээрээ эрэмбэлээд Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: 2026 оны төсөвт тодотгол оруулах зорилго, саналуудтай ерөнхий нь танилцсан, зарчмын хувьд дэмжиж байгаа. Зүгээр одоогийн статистик мэдээллийг харахаар 7 сарын сүүлийн байдлаар гэхэд 2 их наядын алдагдалтай явж байгаа төсөв өөрөө. Тэгээд тэр алдагдал юунаас болж байна вэ гээд харахаар тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл нь өөрөө муу байсантай холбоотой, татварын орлого бага байгаа, тийм ээ? Тэгэхээр орлогын төлөвлөгөөг ирж байгаа хугацаанд, үлдэж байгаа хугацаанд орлогын төлөвлөгөө тэрүүгээрээ биелээд, тэгээд нэмж энэ алдагдал нэмэгдэхгүй гэдэг ийм тооцоололтой байна уу гэдэг ийм асуулт байгаад байгаа юм. Яагаад гэхээр хэрвээ дахиад татварын орлого чинь яг төлөвлөснөөрөө орж ирэхгүй бол алдагдлын хэмжээ маань дахиад нэмэгдэх гээд байгаа. Тийм учраас энэ дээр ямар тооцоололтой байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

Б.Заяабал: Сангийн сайд Мэндсайхан сайдын микрофоныг өгье.

З.Мэндсайхан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоо 2 дугаар улирлын гүйцэтгэлээр 2.2 их наядын төсвийн тасралттай явж байна. Төсөв ерөнхийдөө орлогын тасалдал юунаас үүдэлтэй гэхээр, нэг талдаа бид багш, эмч нарын цалингийн дутаж байгаа эх үүсвэрийг 5 сард ачаалж гаргасан байгаа. Оны эцэс рүү тавигдах ёстой зардлуудыг урагш нь татаад энэ зохицуулалтыг хийсэн учраас мөнгөн хөрөнгийн урсгал дээр ачаалал үүссэн. Оны эцэс хүртэл ерөнхийдөө бид энэ татварын орлогоо бариад гарчихна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Яагаад

гэхээр, хэдийгээр бид 90 сая тонн нүүрс төсөвлөсөн, дундаж өртгийг 70 ам.доллараар тооцоод 26 оны төсвийг бэлтгэсэн байгаа. Гэхдээ өнөөдрийн байдлаар төсөвлөсөн үнийн хэмжээнд зах зээлийн үнэ ирээгүй байна, одоо 68 руу орж ирж байна. Тэгэхээр нүүрсний экспортын биет хэмжээ 8 сарын байдлаар, өнөөдрийн байдлаар 80 сая тонн гарчихсан байна. Тэгэхээр он дуустал бид дор хаяж 100 саяыг экспортод гаргачихна. Төлөвлөсөн экспортын хэмжээ биет хэмжээгээрээ өснө. Ингээд бид төлөвлөсөн татварын орлогоо бүрдүүлээд, төлбөрийн тэнцлээ хангаад гарчих боломж байна гэж харж байгаа, тооцооллоо бид.

Б.Заяабал: Баярлалаа. Уянга гишүүний микрофоныг өгье.

Б.Уянга: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхнаас энэ шатахууны нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлж байгаа ажлынх нь явцыг асуух хэрэгтэй байгаа юм. Яг одоогоор хэчнээн метр куб агуулах шинээр барьж өргөтгөсөн байна вэ, аж ахуйн нэгжийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахтай холбоотой? Тэгээд энэ дээр яг аль, аль газрууд энэ зээлийг авсан юм, одоогоор яг баригдчихсан байгаа нь хэд вэ? Төсвийн тодотгол дээр болохоор 20 тэрбум төгрөг үргэлжилнэ гээд тавьсан байгаа. Тэгээд нэг зүйлийг УИХ-ынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хэлэх нь зүйтэй байгаа. Тэгэхээр энэ үнэхээрийн бид нараас бараг үл хамаарах шахуу асуудлаас болоод шатахуун Монгол Улсад хомсодсон нөхцөл байдал үүссэн. Хэд хэдэн удаа хомсдох үед нь өөрийн биеэр яаманд ажиллаж байсан хүний хувьд манай яам харьцангуй сайн авч гарч байна гэж харж байгаа. Цааш цаашдаа юу болох нь мөн л геополитикийн /geopolitical/ нөхцөл байдалтай хамааралтай байгаа.

Тэгээд яг энэ хүнд үеийг давахад зүгээр хамгийн үл ойшоогдсон байдалтай ч юм уу, нэлээн тийм хөдөлмөр нь үнэлэгдээгүй хэсэг бүлэг хүмүүстээ талархал илэрхийлэх хэрэгтэй байгаа, шатахуун түгээх газруудад ажиллаж байгаа түгээгч нартаа. Цааш цаашдаа олон асуудлууд үүсэх вий, тэр болгонд хамтраад асуудлыг давж туулахын төлөө ажиллах хэрэгтэй байгаа. Тэгэхээр энэ шатахууны нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн, цаашдаа авч хэрэгжүүлж байгаа, төсвийн тодотгол дээр суусан ажлууд гээд тодруулах мэдээллүүдийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас өгөөрэй.

Хоёрдугаарх нь болохоороо Эдийн засгийн байнгын хороо өнөөдөр хуралдаж байгаа юм чинь чуулган дээр асуусан асуултдаа бүтэн хариулт авъя гэж бодож байна. Одоо түрүүн Соронзонболд гишүүн ч гэсэн хэллээ, татварын орлого буухаар байгаа сүүлийн хэдэн саруудад 2026 он дуустал. Тэгэхээр энэ худалдаа, үйлчилгээний салбар уналтад орсонтой холбоотой. 15, 16 жил худалдаа, үйлчилгээний ажил эрхэлж байгаа нөхдүүд анх удаа бид зээлээ төлж чадахгүй нөхцөл байдалд хүрлээ гэсэн асуудлууд ирж байгаа. Бараг ковидын /covid/ үеэс илүү худалдаа, үйлчилгээний салбар уналтад ороод байна гэсэн мэдээллүүд ирсэн байгаа. Тэгэхээр яг юунаас болоод худалдаа, үйлчилгээний салбар уналтад оров? Цаашдаа ямар аргуудыг авч хэрэгжүүлэх вэ, яаж энэ салбарыг эргэж сэргээх вэ гэдэг дээр ямар төлөвлөлтүүд бодлогын түвшинд авч хэрэгжүүлж байна вэ?

Б.Заяабал: Уянга гишүүний асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, дараа нь Эдийн засаг, хөгжлийн яам бэлдэж байгаарай. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэвийн микрофоныг нээе. Индрийн микрофон нээе.

Б.Дашпүрэв: Сайн байцгаана уу. Уянга гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. 2026 оны

улсын төсөв дээр нийтдээ 300 мянган метр куб агуулах сав барихад зориулж улсын төсвийн татаасаар 20 тэрбум төгрөг суулгасан, 2027 оны улсын төсөв дээр 40 тэрбум төгрөг суулгаж явж байгаа. Өнөөдрийн байдлаар 300 мянган метр куб агуулах савны төсөл хэрэгжиж, энэ ондоо 150 мянган метр куб сав ашиглалтад орох ийм төлөвлөгөөтэй. Бид бүхэн улмаар 2028 он гэхэд Монгол Улсынхаа нийтдээ 3 сарын нөөцийг хадгалах ийм боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Баярлалаа.

Б.Заяабал: Эдийн засаг, хөгжлийн яамны дэд сайд Даваасүрэн сайд байна уу? Газрын дарга индэр дээр, Мөнх-Эрдэнэ даргын микрофоныг өгье, индрийн микрофон өгье.

Б.Мөнх-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Энэ жил, 2026 оны тухайд бол худалдаа, үйлчилгээний салбар уналттай гарч байгаа. Хамгийн их ажлын байр шингээдэг салбар хэдий ч уналттай гарсан байгаа. Тэгээд биднүүсийн тооцоо, дүгнэлтээр бол хамгийн 1 дүгээр хүчин зүйл бол инфляц нөлөөлсөн, инфляц өөрөө худалдаа, үйлчилгээний салбарын гол нөлөөлөх хүчин зүйл болоод байна. Инфляц маань харин өөрөө юунаас шалтгаалсан бэ гэхээр гадаад нөхцөл байдлаас шалтгаалсан шатахуун, мөн дотоод нөхцөл байдал буюу мах, гурил, төмсний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Тэгээд дам нөлөөгөөр худалдааны салбар агшихад нөлөөлсөн гэж үзэж байна. Тэгээд цаашдын бодлогын арга хэмжээ болбол эрэлт, нийлүүлэлтийн инфляцыг аль алийг нь зохистой түвшинд барьж явах нь чухал гэж үзэж байгаа. Ялангуяа нийлүүлэлтийн инфляц.../минут дуусав/

Б.Заяабал: Индрийн микрофонд дахиад нэг минутаар нэмж өгье, гүйцэт товч хариулъя.

Б.Мөнх-Эрдэнэ:Тэгэхээр нийлүүлэлтийн инфляц одоо нийт инфляцын 60-аас 70 хувийг эзэлж байна. Одоогийн төсвийн тодотгол, төсвийн төслүүдэд нийлүүлэлтийн инфляцыг хязгаарлахад хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байгаа, мах, шатахуун, гурил, хүнсний ногоо гээд. Дээрээс нь валютын ханш худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд чухал нөлөөтэй. Тэгэхээр бодлогын хувьд бол экспортыг нэмэгдүүлэх, гадаад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, валютын орох урсгалыг тогтвортой хадгалах ийм хүчин зүйлс болно гэж үзэж байгаа. Тэгэхээр макро талаасаа инфляц , валютын ханш худалдаа, үйлчилгээний салбарын хамгийн чухал хүчин зүйл байгаа.

Б.Заяабал: Уянга гишүүний микрофоныг өгье, тодруулах.

Б.Уянга: Онолын дагуу л хариулт өгч байна л даа, ер нь мэдэж байсан л даа. Тэгэхдээ нэг ийм асуудлыг нь ингээд дэмжчих юм бол цаашдаа яаж худалдаа, үйлчилгээнийхээ салбарыг сэргээх вэ гэсэн байдлаар хариулт авахыг хүссэн юм. Мэдээж инфляцтай холбоотой гэдгийг нь энд байгаа бараг бүх хүн мэдэж байгаа байх. Тэгэхээр одоо ямар үйл ажиллагаа явуулж байгаа гэдэг дээр эсвэл сайд хариулах юм болов уу? Мэндсайхан сайд нэлээн их уул нь чуулган дээр мэдэгдэж байсан даа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхнаас болохоороо яг тийм тодорхой мэдээллийг нь бичгээр л авъя даа, яг ямар ямар газрууд зээл авсан юм бол, тус тус хаана хаана барьж байгаа юм бол, тэгээд хүчин чадлыг нь. Тэгээд хариултыг нь явуулчхаарай.

Б.Заяабал: Уянга гишүүний асуулт, тодруулгын дагуу дэлгэрэнгүй хариултыг албан бичгээр өгөөрэй, холбогдох яамдууд гэдгийг хэлье. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Төсвийн тодотголыг дэмжиж байгаа. Ялангуяа худалдааны салбарын уналт гэдэг яг цаанаа яг иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг худалдан авах чадвар буурсан гэдгийг илтгэж байгаа үзүүлэлт л дээ. Би 10 гаруй жилийн өмнө Японд тухайн үед Шинзо Абэ гээд Ерөнхий сайд байсан, яг ийм худалдааны салбар унаад дефляцитай /deflation/ болж эхэлж байсан. Зарим дефляци инфляцаас илүү аюултай гэж тухайн үед дүгнэж, ганцхан зүйлийг хэлж байсан, цалин, орлого, тэтгэвэр, тэтгэмжээ нэм гэдэг, энэ ч гэсэн өөрөө эргээд тодорхой хугацааны дараа үр дүнгээ өгсөн. Худалдааны салбар унана гэдэг чинь ажлын байр хамгийн их шингээдэг. Одоо бараг яг өнөөдрийн байдлаар хэд байна вэ, төрийн албаны салбар гэдэг чинь өөрсдөө худалдан авагч нар. Тэгэхээр бид энэ тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлсийг нэмэхээр шууд аваачаад л, хүмүүс аваачаад л одоо бараг хилийн цаашаа гараад явчих ч юм шиг л юм бодоод байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр тодорхой хэмжээний, одоо инфляц ийм байгаа үед орлогын тохируулгыг хийх нь зайлшгүй.

Нөгөө талаасаа энэ цалин хөлсний асуудал дээр нэг ойлголт юугаа нэгтгэж авахгүй бол одоо сүүлдээ цалин нэмсэн салбараа бараг ад үзэх хандлагатай хүмүүс ч гэсэн их гарч ирдэг боллоо л доо. Тэгэхээр энэ ачаалал, норм, эрэлт хэрэгцээ, энэ хөдөлмөрийн зах зээлийн аль салбарт ямар хүн, боловсон хүчин дутаад байгаа энэ тэр гэдгээ сайн ойлгож тавихгүй бол, одоо яг ний нуугүй хэлэхэд боловсрол, эрүүл мэнд манай суурь салбар шүү дээ. Тийм учраас энэ хүмүүсийн цалин хөлсний асуудлыг бид өнгөрсөн намар төсөв ярихдаа улс төрийн шийдвэр хамтдаа гаргацгаасан, бүгдээрээ л дэмжсэн, багш нарынхаа, эмч нарынхаа. Одоо иргэд юу болчхов уу, яачхав уу гэдэг зүйл. Би тухайн үед яг төсөв баталж байхад би хэлсэн, дутна мөнгө дутна, энэ тал дээр нь тодорхой хэмжээний зохицуулалтыг хийхгүй бол эргээд л наад нэг дуусдаггүй асуудал чинь ирнэ гэж. Тийм учраас одоо энэ цалин хөлс нэмснээр энэ салбаруудтай холбоотой маргаанууд дуусах дуусна биз дээ гэдгийг би холбогдох яамдаас асуумаар байна?

Дараагийнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ төсвөө болж өгвөл хасмааргүй байгаад байгаа юм. Би энэ талаар тодорхой саналаа хэлсэн, ирэх оны төсөвт саналуудаа өгсөн. Тухайлбал нэг аймагт гэхэд нэг ганцхан тэрбум төгрөг хувааж өгч байгаа байхгүй юу, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гээд. Тэгэхээр цаашдаа болж өгвөл яг энэ хувийн хэвшлийн салбарт байж байгаа, ажил хөдөлмөр хийе гэж байгаа хүмүүстээ энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаа хасмааргүй байгаад байгаа юм. Энэ тал дээр одоо та бүгд маань яах вэ, би төсвийн 27 оны төсөв дээр энийг ярьж гэж бодож байна, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаасаа хасаагүй биз дээ гэдгийг би зүгээр тодруулаад асуучихъя. Тэртээ тэргүй хасчихсан, оны эхэнд нэг зарим аймагт 2 тэрбумыг өгдөг байсныг 1 тэрбум болгоод, тэгэхээр энэ зүйлийг давхар ерөөсөө хасаж болохгүй юм байна гэж.

Дараагийн нэг асуулт нь Монголбанкнаас асуумаар байна, одоо энэ зээлийн хүү цаашдаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл явж байгаа учраас энэ бодлогын хүүг инфляцтайгаа хамаараад одоо ингээд нэмээд яваад байх уу? Сая 0.5 хувиар, пунктоор /point/ нэмчихлээ, энэ чинь цаанаа яах вэ гэхээр дахиад зээлийн хүүнүүдийг өсгөх эрсдэлтэй, зээлийг тодорхой хэмжээгээр хумих, эргээд нөгөө банк,

санхүүгийн байгууллагууд руу л иргэд хүүд зардлаа өгөөд байна шүү дээ, зээлийн хүүд.

Боловсролын яамнаас нэг зүйлийг асуумаар байна, энэ сургалтын төлбөр гэдэг зүйл чинь нэг талаараа өрхийн, айл өрхийн орлогод асар их сургалтын төлбөрүүд нэмэгдсэн байна лээ, мөн дээрээс нь ахмадууд хүртэл хүүхдээ хот явахад нь зээл авч л сургалтын төлбөрийг нь төлж байгаа байхгүй юу. Сургалтын төлбөр дунджаар 20, 30 хувь нэмэгдчихсэн байгаа үед өрхийн орлогод яг ямар нөлөөлөл үзүүлж байна вэ гэдгийг асуумаар байна. Хэчнээн хүүхэд сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл авъя гээд хүсчихсэн байгаа юм, хэдийг нь хангаж байгаа вэ гэдгийг тодруулж асуумаар байна. Тэгээд зарчмын хувьд энэ төсвийнхөө тодотголыг дэмжиж байна гэдгийг хэлмээр байна.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүний асуултад Сангийн яам, Монголбанк хариулна. Боловсролын яамнаас энд манай Байнгын хороонд төлөөлөл орж ирээгүй байгаа, гишүүнээ, эрхлэх асуудал нь биш учраас орж ирээгүй байгаа. Та холбогдох Байнгын хороо, чуулган дээр асуултаа асуухыг хүсье. Ингээд Сангийн яам индрийн микрофоноос. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Санжаадорж индрийн микрофонд, дараа нь Монголбанкны Ерөнхийлөгч Наранцогт.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж, гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр бол энэ жилийн хувьд 106.7 тэрбум төгрөгийн зарлагыг санхүүжүүлэх төсөв батлагдсан байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан бол 2026 оны төсвөөс ер нь бууруулаагүй. Нөгөө талдаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан өөрөө эргэлтийн шинжтэй сан байдаг, гадаадаас ирсэн ажиллах хүчний төлбөрөөр энэ сан бүрэлддэг, өөрөөр хэлбэл бид зардлыг нь хасаад улсын төсөвтөө авдаггүй сан гэсэн үг. Тэгэхээр энэ салбар дээр хэрвээ ямар нэгэн төсөв байх юм бол дараа жилдээ эх үүсвэр олгогдоод ингээд ашиглагддаг ийм учиртай байгаад байгаа юм.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 7, индрийн микрофон дээр Наранцогт Ерөнхийлөгчийн микрофоныг нээе.

С.Наранцогт: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр түрүүн Эдийн засгийн хөгжлийн яамнаас ярьсан, хэдийгээр инфляцын 60 орчим хувь нь нийлүүлэлтийн гаралтай цөөхөн бүтээгдэхүүнээс хамаарч байгаа боловч ер нь үнэ нэмэгдэж байгаа бүтээгдэхүүнүүдийн тоо нэмэгдэж байгаа, суурь инфляц нэмэгдэх хандлага руу орж ирж байгаа. Тэгэхээр энэнээс урьдчилан сэргийлэх, инфляц өргөжихөөс хамгаалж бид мөнгөний бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тэгэхээр бид одоо 0.5 хувиар бодлогын хүүг нэмсэн. Цалин тэтгэврийн нэмэгдэл, цалин тэтгэвэр өөрөө шууд хэрэглээ рүү гардаг, тэгэхээр хэрэглээ рүү гарна гэдэг маань инфляцыг нэмэгдүүлнэ. Цалин тэтгэврийнхээ энэ өсөлтийг буцаагаад нөгөө инфляцад идүүлэхгүйн тулд Төв банк мөнгөний бодлогоо хатуурхах ийм л чиглэл рүү явахаас өөр аргагүй байдал руу орно. Тэгэхдээ бид тийм.../минут дуусав/

Б.Заяабал: Наранцогт Ерөнхийлөгчийн микрофоныг нээчихье, дуусгаад.

С.Наранцогт: Тэгэхээр ер нь Төв банкнаас оны эхнээс ямар бодлого барьж байна вэ гэхээр, валютын ханшийг ч гэсэн түрүүн ярьсан, инфляцад нөлөөлж байгаа нэг гол үзүүлэлт, тэгээд дээр нь гадаад цэвэр активаар /asset/ нэмэгдэж байгаа энэ илүүдэл нөөцийг бид Төв банкны үнэт цаасыг нэмэгдүүлэх журмаар

соруулж байгаа, зээлийн хэмжээ зохих түвшинд очиж байгаа макро зохистой бодлогыг хэрэгжүүлсэн. Тэгээд явж явж бид нарын гол зорилго энэ суурь инфляцын өсөлтийг хязгаарлах нь Төв банкны үндсэн үүрэг. Тэгээд энэ чиглэл рүүгээ бид тууштай арга хэмжээ, бодлогоо авч хэрэгжүүлж явна. Энэ нь эцэстээ иргэдийн энэ нэмэгдэж байгаа орлогыг инфляцад идүүлэхгүй байх гэсэн ганцхан бодлогыг хэрэгжүүлж байгаа гэж ойлгож болно.

Б.Заяабал: Болчихсон уу? Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тодотгол дээр Хятад улсаас эрчим хүч импортлох 50 тэрбумын татаас ингээд орж ирж байгаа. Тэгээд Монгол Улсын эрчим хүчний системийн хувьд өвлийн 3 сар оройны 17 цагаас шөнийн 21 цагийн хооронд л дутагдалтай байдаг, бусад бүх цагуудад эх үүсвэрийн илүүдэлтэй байдаг. Тэгээд Хятад улсаас яг ийм дутагдалтай үед эрчим хүч авна гэж анх ойлгож байсан, гэтэл энэ үлдэж байгаа хэдхэн сарын дотор 150 сая квт.цаг авна. Тэгээд тариф нь 9 цент /cent/ учраас тэрнээс болоод энэ жил бид нарт зөвхөн үлдэж байгаа саруудад 50 тэрбумын татаас орж ирж байна. Тэгэхээр энэ Зэс оюу гэдэг энэ станцыг бариад Хятадаас эрчим хүч импортлох энэ шийдэл нь ерөөсөө эрчим хүчний хараат байдлыг нэмэгдүүлэх ийм л үйл ажиллагаа болсон.

Уг нь бид яг энэ дутагдалтай, энэ оргил ачааллыг хаах том чадлын батарей /battery/ станц, 50 тэрбумаар хөөрхөн хэмжээтэй батарей станцыг зургаахан сарын дотор оруулах бүрэн бололцоотой. Гэтэл энэ өвлийн хэдхэн сарын, хэдхэн цагийн дутагдлаас болоод импортын хараат байдлаа, одоо бид Оюу Толгойг Хятад улс руу бүрэн халдчихсан, Оюу Толгой жилдээ 500 тэрбумын цахилгааныг Хятадаас худалдаж авч байна. Одоо энэ 50 тэрбумын татаас улсын төсөвт суугаад Өмнөговь аймгийг тэр чигээр нь Хятадаас тэжээдэг болно. Тэгээд зөвхөн дутагдалтай үедээ авах юм байх даа гэж бодсон чинь ингээд өвлийн саруудад маш их хэмжээний цахилгаан авна, тэрнээс болоод энэ жил 50 тэрбумын татаас, ирэх онд хэдэн тэрбумын татаас бий болох юм. Ингэж их хэмжээний татаас, ингэж хараат байдлаа нэмэгдүүлэхийн оронд энэ их мөнгөөрөө бид яг л оргил ачааллынхаа дутагдалтай үеэ хаах тийм л эх үүсвэрээ дотооддоо барих ёстой байсан шүү дээ. Том чадлын батарей станцыг бид хэдхэн сарын дотор оруулах байсан. Ус хуримтлуурын станц аль хэдийн ТЭЗҮ нь хийгдчихсэн өчнөөн ус хуримтлуурын станцууд байгаа. Тэгэхээр ямар буруу бодлого, улсын, үндэсний аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан ийм шийдвэр гаргачхаад энэнийхээ төлөө маш их хэмжээний татаас одоо ингээд улсын төсөв дээр суулгачхаад, тэгээд хээвнэг ингээд яриад зогсож байгаа юм.

Тэгэхээр Эрчим хүчний яамнаас асуулт байна л даа. Өвлийн улиралд өдөрт хэдэн цагаар Хятадаас цахилгаан авна гэж төлөвлөсөн юм бэ? Диспетчерийн үндэсний төв анхны тооцоогоор 40 сая квт.цаг авна л гэсэн ийм бичиг надад ирсэн. Одоо тэгтэл 150 сая квт.цаг, тэрнээс болоод 50 тэрбумын татаас. Тэгээд чухам аль аймгийг Хятадаас тэжээнэ гэж байгаа вэ, Өмнөговь аймгийг тэр чигээр нь Хятадаас, хаана таслаад, аль аймгийг Хятадаас тэжээнэ гэсэн ийм төлөвлөгөө гаргасан юм бэ? Яагаад 50 тэрбумын татаас орж ирж байгаа вэ, энийг бага байлгах бодлого баримталж ажиллах боломж байхгүй байсан уу гээд ийм асуултуудад хариулаач. Тэгээд ирэх онд энэ татаас хэдэн тэрбум болж нэмэгдэх юм бэ? Тэгээд асуулт дахиж нэмж асууя.

Б.Заяабал: Эрчим хүчний яамнаас, тэгье, эхлээд Сангийн сайдын микрофоныг нээе, дараа нь манай Эрчим хүчний яамны бодлогын газрын дарга бэлдэж байгаарай. Сангийн сайдын микрофоныг нээе.

3.Мэндсайхан: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ жил Засгийн газар хэрэглэгчдийнхээ хувьд цахилгаан, дулааны үнийг нэмэхгүй 26-аас 27 онд шилжих өвөлжилтийн хүрээнд. Эрчим хүчний салбарын эх үүсвэр талдаа найдвартай ажиллагааг нь хангах үүднээс засвар хөдөлгөөнт засвар урсгалын ажлыг нь дуусгаж өгье гэдэг дээр 92.7 тэрбум төгрөг, таны ярьж байгаа асуудал дээр нийтдээ 3 газраас импортоор цахилгаан эрчим хүч импортлож байгаа. Энэ дээр 107.3 тэрбум төгрөгийн татаасыг тавьж өгч байгаа. Засгийн газрын бодлого, ерөнхийдөө хэрэглэгчдийнхээ дулаан, цахилгааны үнийг нэмэхгүй гэж.

Тэгэхээр таны асууж байгаа дээр Хятадаас эрчим хүч импортлоход 51.4 тэрбум төгрөгийг хэрэглэгчдийн цахилгаан, дулааны үнийг нэмэгдүүлэхгүй зөрүү татаас дээр л Засгийн газар оруулж ирж байгаа. Энийг төлөвлөхдөө бид Эрчим хүчний яамнаас асуусан. Энэ би одоо маш тодорхой хэлэхэд энэ Оюу Толгой хэрэглээ юу, үнэхээр иргэдийн болон Өмнөговь аймаг, өмнөд бүсийн аж ахуйн нэгжүүдэд дутагдаж байгаа хэрэглээ юу гэдгийг тодруулсан. Диспетчерийн үндэсний төвийнхөө гаргасан тооцоог тухайн үед танилцуулаад энэ Оюу Толгойдoo хамаагүй юм гэж тайлбарласан. Тийм учраас Засгийн газар, Сангийн яам энэ чиглэлээр нь татаасаа боловсруулж орж ирсэн. Яг таны асуугаад байгаа тэр технологийн техникийн шинжтэй юмаа Эрчим хүчний яам хариулах нь зөв байх.

Б.Заяабал: Эрчим хүчний яам, индрийн микрофонд.

Г.Энхтүвшин: Энхтүвшин, Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. БНХАУ-аас импортолж, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхтүвшин. Хятадаас авч байгаа импортын цахилгаан эрчим хүчээр Өмнөговь аймгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах байгаа. Яг сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор оргил ачааллын үргэлжлэх хугацаа урт болсон, орой 5 цагаас эхлээд 11 цагийн хооронд оргил ачаалал ингээд үргэлжилж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд Хятадын импортын эрчим хүчээр орой 5-аас 11 цагийн хооронд байгаа энэ цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаар төлөвлөсөн байгаа.

Ирэх жилийн хувьд бид Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний компанитай жилээр ингээд хангах цахилгаан эрчим хүчнийхээ хэмжээг ингэж тохирч явах учраас ирэх жилийнхээ хэрэглээний өсөлтийн прогнозыг /prognosis/, прогноз дээр тулгуурлаад Өвөр Монголын.../минут дуусав/

Б.Заяабал: Индрийн микрофонд нэмэлт өгье.

Г.Энхтүвшин: Ирэх жилийн хувьд хэрэглээний өсөлтийн төлөв байдлыг харсны үндсэн дээр Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний компанитай 27 оныхоо импортолж авах цахилгаан эрчим хүчний хэмжээг тохироод явна. Баярлалаа.

Б.Заяабал: Энхцэцэг гишүүн, тодруулга.

М.Энхцэцэг: Асуултад тодорхой хариулахгүй байна л даа. Өдөрт яг хэдэн цагаар авахаар төлөвлөсөн бэ? Чи сая өөрөө хэллээ шүү дээ, 17-гоос 23 цагийн

хооронд л дутагдалтай буюу өдөрт 6 цагийн л дутагдалтай. Тэгэхээр энэ үлдэж байгаа 3 сар өдрийн 6 цагаар авахаар ийм их хэмжээний татаас үүсэхгүй. Тэгэхээр өдөрт хэдэн цагаар авах болоод ийм их хэмжээний цахилгааныг авахаар болгочхож байгаа юм бэ гээд 1 дүгээрт асуултад хариул.

2 дугаарт болохоор, энэ 50 тэрбумын татаасаар уг нь 6 сарын дотор ямар хэмжээтэй батарей хуримтлуурыг оруулах боломжтой, тэр батарейгаараа зөвхөн энэ оргилыг хаах боломжтой байсан бэ? Энд хариул. Би дахиад асууна.

Б.Заяабал: Тодруулга хариулт өгье, индрийн микрофон.

Г.Энхтүвшин: Гишүүний асуултад тодруулъя. Татаасны хувьд 8, 9, 10, 11 дүгээр саруудад цахилгаан эрчим хүч импортоор авахаар төлөвлөсөн. Би танд мөн хэллээ, орой 5 цагаас 23 цагийн хооронд бол импортоор эрчим хүч авна. Батарей хуримтлуур болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих бүрэн боломжтой. Энэ хүрээндээ ч гэсэн эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 10 гаруй ийм батарей хуримтлуурын өөрийгөө цэнэглэх ийм шийдэл бүхий төслүүд хэрэгжихээр явж байгаа. Мөн Эрчим хүчний яамнаас энэ онд өвлийн оргил ачааллыг давахын тулд 220 мвт-ын нарны станцыг 5 байршилд шуурхай хэрэгжүүлэхээр ингээд auction зохион байгуулаад явж байгаа. Тэгэхээр энэ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн тодорхой хувь хэмжээ нь ашиглалтад орсноор өвлийн оргил ачаалал.../минут дуусав/

Б.Заяабал: Нэмэлт тодруулга, Энхцэцэг гишүүн, дараагийн асуулт.

М.Энхцэцэг: Дараагийн асуулт, та Эрчим хүчний яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга байсан, одоо ингээд Төрийн нарийны үүрэг гүйцэтгэж байгаа юм байна. Тэгэхээр Эрчим хүчний яамны хуулийн өмнө хүлээсэн үүрэг энэ салбарын стратеги, бодлогыг боловсруулах. Гэтэл цахилгаан экспортлох стратегийг 790 саяар боловсруулаад явж байна. Энэ хэр зүйтэй юм бэ? Та бүхэн бүхэл бүтэн хуулийн өмнө хүлээсэн үүргээ хийхгүй байна. Тэгэхээр ийм их мөнгөөр, ийм татвар төлөгчийн мөнгөөр та нар өөрсдийнхөө хийх ёстой ажлыг тендер болгочхоод явж байна. Одоо энэ тодотгол орж ирж байгаа үндэслэл чинь ерөөсөө л энэ үргүй зардлыг багасгая, хэмнэе, өөрсдөө хийх ёстой ажлаа хийе л гэж байгаа шүү дээ. Гэтэл та нар хэвнэг 790 саяар стратегия боловсруулна, хүнээр боловсруулна, бид чадахгүй гээд ингээд сууж байгаа. Энд нэг тодорхой хариулт өгөөч. Та яг энэ Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга байсан хүн шүү дээ?

Б.Заяабал: Индрийн микрофон.

Г.Энхтүвшин: Гишүүний асуултад хариулъя. Энэ болохоор хуулийн хүрээндээ энэ Шадар сайдын ажлын албанаас чиг үүргийн дагуу энэ төслийг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр оруулж ирсэн юм байна лээ. Тэгэхээр тэр хуулийн хүрээнд энэ зохион байгуулж байгаа арга хэмжээ гэдгээрээ явах байх.

Б.Заяабал: Нэмэлт асуулт өгөхөөр гишүүд нэрээ өгсөн байгаа. Ингээд Мөнхсоёл гишүүн, Мандхай гишүүн, Цэнгүүн гишүүн, Баатархүү гишүүн, Цогтбаатар гэсэн ийм 5 гишүүний нэрийг оруулж өгье. Цэнгүүн гишүүнийг нэмчихсэн, Даваагийн Цогтбаатар гишүүнийг нэмээрэй. Ирцээрээ, ингээд тасаллаа шүү. Мөнхсоёл гишүүн, байгаа, Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өглөөний амар амгаланг айлтгая. Тэгээд Эдийн засгийн байнгын хороотой холбоотой асуултуудыг илүү түлхүү асууя, Төсвийн байнгын хороо дараа нь хуралдана. Ер нь бол энэ төсвийн тодотголтой холбогдуулаад Сангийн яам руу илүү чиглэсэн асуултууд ирдэг. Эдийн засаг, хөгжлийн яам байгаагийн хувьд энэ төсвийн тодотгол, ирэх оны төсвийн тухай хуулийн төсөл дээр хэр ажиллаж байна вэ? Та нар маань хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцдаг, 30 тэрбумаас дээш өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хариуцдаг шүү дээ. Гэтэл энэ хөрөнгө оруулалт чинь багасаад байгаа юм биш үү, энэ тодотголоор хасах 7.6 хувь. Гэтэл урсгал зардал чинь эсрэгээрээ нэмэх 7.9 байна уу? Тэгэхээр энэ дээр та нар маань юу бодож байна вэ? Нөгөө ДНБ-тэй харьцуулахад урсгал зардлын хэмжээ 30 хувиас хэтрэхгүй гэсэн чинь хаана явах гэж байна, одоо өөрчлөгдөөд орж ирэх гээд байна. Энэ дээр танай яамныхан ямар бодол, саналтай байдгийг сонсмоор байна.

2 дугаарт, бид бүгдээрээ мэдэж байгаа. Нэг талдаа цалин, тэтгэвэр одоо юу байдаг юм, эмзэг бүлгийнхэндээ тэтгэвэр, тэтгэмжийг нь нэммээр байгаа. Тийм, Эрдэнэбат гишүүн ганцхан санаа зовоогүй, бид бүгд энийг хүсэж байгаа шүү. Сонгогчдоо бодно, иргэдээ бодно. Мөнгө нь хаана байна, мөнгө? Тэгээд 2 дугаарт, энэ өгч байгаа мөнгө маань яг өнөөдөр сая төгрөгөөр 2 талх авдаг байсан бол жишээлбэл, одоо бусад олон юмнуудаа оруулаад 1 сая 500 мянга ч байдаг юм уу эсвэл 1.3 сая болгоод яг авдаг юм нь өсөж байна уу, үгүй юү, харин ч буурах гээд байна уу энэ утгаараа эдийн засгийн онол, мэдлэгтэй хүмүүсийн хувьд зарим гишүүд инфляцаа бариач, инфляцдаа гол тогтвортой эдийн засагтаа анхаараач гээд хэлээд байгаа шүү дээ. Тэгэхгүй нэг газар нэг хүн нэг юм яриад, нөгөө газар нөгөө хүн өөр юм яриад, эсрэг байгаа юм шиг харагдуулахыг тэвчишгүй.

Тэгэхээр ийм байна. Тогтвортой орлогын суурь алга. Одоо энэ төсвийн тодотгол дээр бид бүгдээрээ мэдэж байгаа, энэ дотор байгаа бүх хүмүүс ерөөсөө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт /ТӨБЗГ/ нэмэлт орлого, нэг удаагийн шинжтэй орлого орж ирснээс болоод одоо бүх тоонуудыг хасаад энэ 908 тэрбумын алдагдалтай байгаа төсөв дээр нэмэлт зарлага орж ирж байгаа. Тэгсэн мөртөө алдагдлын хэмжээ 1 их наядаар өсөж байгаа. Тэгэхээр тоо боддог бүх хүмүүс байна, дээрээс нь тооны ард ямар утга явж байгааг бүгд мэдэж байгаа. Энийгээ одоо иргэдийнхээ төлөө итгэл үнэмшилтэйгээр, үнэн шударгаар хариулж сурмаар байна гэж хэлмээр байна.

Тэгээд нэмээд нэг зүйл сануулахад, Эдийн засаг, хөгжлийн яам илүү анхаарууштай, Эдийн засаг, хөгжлийн яам өөрөөр хэлэх юм бол цаанаа макро эдийн засгаа харна, мөн хувийн сектороо анзаарна гэсэн үг. Гэтэл Татварын ерөнхий газрын одоо оруулах ёстой орлогын эх үүсвэр нэмэгдчихсэн буюу 6.9 хувь байна шүү дээ, өсөөд. Бусад тэр ГЕГ, Сангийн яам, тэр гадаад тусламж эд нар чинь бүгд буурчихсан буюу хасах байна. Гадаад тусламж -10, ГЕГ-ын оруулах орлогын хэмжээ арав аравны хэдэн хувь ч байна, 6 ч билүү, татварын ерөнхий юу билээ, ГЕГ -28 энэ тэр гээд. Тэгэхээр нөгөө түрүүний гишүүдийн асуугаад байгаа, юунаас болоод бид ийм эдийн засгийн ийм эмзэг байдалд орсон бэ гэдэг шалтгаануудаа сайн судалмаар байна. Одоо удахгүй мөнгөний бодлого ярина, ирэх оны төсөв ярина. Дахиад л нөгөө онолын хувьд бүгд мэддэг юмаа яриад, яг шийдэлгүй, нэг давтамжтайгаар тоо жоохон өөрчлөгдөөд юмнууд яриад. Чуулган дээр ч би хэлсэн, бие биеэ хуураад ингэхийгээд инерцээрээ урагшлаад явах юм байна. Одоо бүгд энэ улсын иргэн хүний хувьд, аав ээжийн хувьд, том хүмүүсийн хувьд нухацтай

бодъё, реформоо хийе, үнэн байя гэж уриалмаар байгаа юм. Асуултынхаа хариултыг тодорхой авна шүү. Зөндөө юм асууж болно, ингээд дуусгая.

Б.Заяабал: Эдийн засаг, хөгжлийн яам индрийн микрофон дээр ирье. Танай дэд сайд яасан юм бэ? Танилцуулаад хариул даа.

Б.Мөнх-Эрдэнэ: Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч, гишүүний асуултад хариулъя. Урсгал зардал ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлага тоо тооцооллоор биелж байгаа. Бид хэдий ч Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх тухай хуулийг дагалдуулаад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Түүгээр хуучин мөрдөж байсан буюу уул уурхайн бус эдийн засгийн өсөлтөөс төсвийн зардлын өсөлт хэтрэхгүй байх ёстой гэсэн тусгай шаардлагыг оруулж ирэхээр төлөвлөсөн байгаа.

2 дугаарт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтүүд манай жилийн төлөвлөгөө дээр ороод явдаг. Хавар батлуулсан жилийн төлөвлөгөөтэй ирэх оны төсвийн төсөл 74 хувийн нийцэлтэй байгаа гэж гарсан, улсын төсөвт суугдах байдал нь.

3 дугаарт, инфляцын тухайд бидний шинжилгээгээр ерөөсөө 4 төрлийн бараа буюу нийлүүлэлтийн гаралтай инфляц 60-аас 70 хувийг эзэлж байна. Ирэх оны инфляцын эрсдэлүүдийг эдийн засагчид ярьсаар байгаа. Эрэлтийн гаралтай инфляцыг цалин, тэтгэврийн нэмэгдэл өдөөнө, гэхдээ зөвхөн энэ өдөөхгүй. Жил жилийн л улсын төсвийн урсгал зардал, жил жилийн л хөрөнгө оруулалтын зардлууд, тэгээд төрийн өмчит компаниудын ч урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал хийгдсэн аль аль нь инфляцад нөлөөлнө. Гол нь энэний индикаторуудыг /indicator/ яаж тооцох, тооцоолох дээр л ажиллаж байгаа. Тэгээд бидний хувьд төсөв маань өөрөө мэдээж урсгал зардлаа санхүүжүүлэх, нөгөө талдаа энэ цөөн нэр төрлийн 4 барааны инфляцыг тогтворжуулахад чиглэсэн нөөцүүдийг бүрдүүлэх, ялангуяа мах, шатахууны нөөц, улаан буудайн нөөцийг бүрдүүлэх чиглэлд ажиллаж байгаа. Тэгээд дүгнэлтээр инфляцад 1 их наяд төгрөгийн төсвийн зардал гарсан тохиолдолд аль ч төрлийн зардал нь гарсан тохиолдолд 0.5 орчим нэгж хувийн инфляцын нөлөө үзүүлнэ. Тэгэхээр ирэх жилийн инфляцын тухайд бид зорилтот түвшин 8 хувь гэдгээрээ орж ирсэн байгаа, түүнээс дээш гарах юм бол бид хүлээлтийг буруу тийш нь эргүүлэх эрсдэлтэй. Тэгээд инфляцын ирэх жилийн 8 хувийн зорилтот түвшин бүтцийн хувьд авч үзэх юм бол нийлүүлэлтийн инфляц маань багасна, 40 орчим хувь руу очиж багасна. Түрүүний миний ярьсан бодлогын хүрээнд эрэлтийн инфляцын бага нөлөөнүүд байгаа. Эрэлтийн инфляцад үүсэх цалин, тэтгэврийн нөлөө 2 улирлын хоцрогдолтойгоор орж ирнэ гэж бид тооцоолж байгаа. Тэгэхээр ирэх жилийн инфляцыг зорилтот түвшинд хангах боломжтой гэж үзэж байна.

Б.Заяабал: Мөнхсоёл гишүүн нэмэлт тодруулга өгье.

Б.Мөнхсоёл: Улс төрийн шинжтэй хариултууд дээр сайд нь байвал их зүгээр байдаг. Тэгээд мэргэжилтэндээ баярлалаа. Чуулган дээр гүнзгийрүүлж асууя. Тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дүрэм нухацтай харах ёстой зүйл шүү гэж хэлье.

Б.Заяабал: Баярлалаа. Мандхай гишүүний микрофоныг өгье.

М.Мандхай: Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэг зүйл асууя. Бид 26-аас 30 онд 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан байгаа. Одоо 26 онд хийж байгаа ажил, одоо ингээд нэмэгдэл ярьж байна, 27 оны төлөвлөгөө, ингээд 30 он руу бид ойртоход, ер нь ойртоод явж байна. Тэгэхээр энэ төлөвлөгөө чинь ер нь энэ 5 жилийн үндсэн чиглэлтэй хэр уялдаж явж байгаа вэ? Ер нь уялдаад одоо яг энэ 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх түвшинд ажиллаж, энэ төлөвлөлт чинь орсон гэж бодож байгаа юу, хэдэн хувьтай явж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асууя?

2 дугаарт, энэ тооцооноос задаргаа асууя. Өнөөдөр шинэ омгийн өвчлөл, ялангуяа энэ шүлхийтэй холбоотой хэд хэдэн өвчлөл хэд хэдэн бүсэд гарсан. Ингээд төсвийн төлөвлөгөө нэлээн энэнтэй уялдаж зохицож явж байгаа юм болов уу гэсэн чинь эргэлзэх тоонууд гарсан байна. Энэ жижиг, дундыг дэмжих төсөл нийтдээ бараг 4.5 тэрбум төгрөг юм шиг байна, тийм үү? Тэгээд бүхэлдээ энэ чинь дийлэнх нь Улаанбаатар хотод байгаад байна л даа, тоног төхөөрөмж гээд. Гэтэл нөгөө талдаа Улсын төв эмнэлгийн лабораторийн бараг төсвөөс 13.9 дахин их ийм төлөвлөгөө тавьсан байна. Энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж энэ Улаанбаатар хотод 1 дүгээрт төвлөрүүлсэн логик нь юу юм, ямар тоног төхөөрөмжүүд байгаа юм бэ гэдгийг асууя.

2 дугаарт, хоёр яаман дээр хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой, үндсэндээ нэг гинжин хэлхээний хоёр талын ийм төсвийг хоёр өөр сайдын багц дээр тавьсан байгаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр, нэг талдаа болохоор энэ хүнсний бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний одоо энэ дэлгүүрт очих, хүнсний баталгаат байдлыг хангах төсөв Стандарт, хэмжил зүйн газар 4.8 тэрбум төгрөгийн багаж, тоног төхөөрөмж тавьсан байгаа. Гэтэл нөгөө талдаа Хөдөө аж ахуйн сайдын багцад Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори дээр 324 сая төгрөг тавьчихжээ. Ижил чиг үүрэгтэй мөртөө 16 дахин ийм зөрүүтэй гарсан байна. Тэгэхээр энэ үндсэндээ гол мал эмнэлгийн, бид чинь өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлтэй тэмцэх төсөв нь илүү өндөр байгаад, дараа нь хүнсний тэр дэлгүүр дээр очих гинжин хэлхээ чинь өөрөө дараа нь хэрэгжиж байгаа. Тэгэхээр бид нарын энэ тавьж байгаа төсөв дээр яг ингээд логик нь хаана алдагдаад, ингээд яагаад ийм төсөв оруулж ирэв гэдгийг тайлбарлаж өгөөч. Ямар учир шалтгаантайгаар яагаад ингээд тавьчихав? Бид өвчин үүсчихсэний дараа, бид дараа нь ингээд хэчнээн хэмжил зүй хийгээд аварч чадахааргүй хүнсний баталгаагүй байдал лангуун дээр үүсэх ийм эрсдэлтэй түвшинд очиж байхад төсвийнх нь өөрөө тавьж байгаа логик нь өөрөө ингээд буруу, ийм урвуу хамааралтай ингээд тавьчихсан байгаад, энэ дээр нэг хариулт өгөөч?

2 дугаарт, Эдийн засаг, хөгжлийн яамны энэ хөрөнгө оруулалт дээр 14.1 тэрбум төгрөг ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ дээр тавьжээ. Энэ юуны мөнгө юм бэ гэдгийг нэг тодруулаад өгөөч? Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн төсвийг хассан байна лээ. Тэгэхээр энэ Хөдөө аж ахуйн төсвөөс хэд дахин ийм ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээг Эдийн засаг, хөгжлийн яам тавьсан байна, энэ дээр нэг тайлбар өгчхөөрэй, би тэгээд тодруулаад тодруулга хийе.

Б.Заяабал: Гишүүний асуултад Эдийн засаг, хөгжлийн яам, дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн яамны төлөөллүүд индэр дээр хүрээд ирээрэй. Эдийн засаг, хөгжлийн яам. Өнөөдөр Оросын Холбооны Улстай Засгийн газар хоорондын ажлын хэсгийн хуралтай байгаа учраас сайд нар, холбогдох албан тушаалтнууд тэнд уулзалтад байгаа юм байна. Тийм учраас яамны газрын дарга нар өөрийгөө

танилцуулаад, индрийн микрофон дээр хариулаад явъя. Эдийн засаг, хөгжлийн яам.

Ж.Гэрэлбат: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам, Санхүүгийн хэлтсийн дарга Гэрэлбат. Манай дээр нийтдээ улсын төсвөөс 2026 оны хөрөнгө оруулалтын төсөлд 21.7 тэрбум төгрөг батлагдсан. Үүний тендер шалгаруулалтын үр дүнгээр 21.7 тэрбум төгрөг маань 14.1 тэрбум төгрөг болж багассан. Энийг би задаргаагаар нь танд албан бичгээр хүргүүлъя. Нийтдээ 46 төслөөс 30 төслийн гэрээ албажиж байгуулагдсан байгаа. Бүр нэрээр нь задалж хэлэх юм уу, хугацаа хүрэхгүй байх, 46 нэр төрлийн гэрээ байгуулагдахаас 30 төрлийн гэрээ байгуулагдаад, 16 төсөл маань 5 дугаар сарын 31-ний байдлаар татагдсан байгаа.

Б.Заяабал: Хүнс, хөдөө аж ахуйн яамны төлөөлөл хэн байна? Танилцуулаад хариулъя.

Г.Болорсүх: Хүнс, хөдөө аж ахуйн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Болорсүх байна. Таны асуултад хариулахад, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сантай холбоотой юм Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр байдаг, тиймээс энэ асуулттай холбоотой хариултыг би бичгээр, дэлгэрэнгүй мэдээлэл өгье гэж хэлмээр байна. Яг одоогоор бэлэн мэдээлэл алга.

Б.Заяабал: Стандарт, хэмжил зүйгээс хүн байна уу төлөөлөл, индрийн микрофонд хариулъя.

Б.Мягмарцэрэн: Стандарт, хэмжил зүйн газар дээр болохоор эталон багаж авах дандаа, Стандарт, хэмжил зүйн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Мягмарцэрэн. Манай дээр болохоор стандарт, хэмжил зүйн дандаа эх багаж, тоног төхөөрөмжийн зардлууд тавигдсан байгаа. Тэр нь болохоор бид дотооддоо хэмжилтээ хийж, үндсэн хэмжилт хийдэг багажуудаа хэмждэг эх багажуудын тоног төхөөрөмжүүд дээр төсөв тавигдсан байгаа. Нэг бүрчилсэн юуг болохоор албан бичгээр танд хүргүүлъя. Нэмж тавигдаагүй байгаа, байснаасаа хасагдсан байгаа.

Б.Заяабал: Мандхай гишүүн нэмэлт тодруулга авъя. Мандхай гишүүний микрофон өгье.

М.Мандхай: Би ингэж хараад байгаа байхгүй юу, Засгийн газар төсвийг төлөвлөхдөө юу ач холбогдолтой, чухал вэ гэдгээсээ ер нь эрэмбэлж явахгүй бол одоо бид малын гоц халдварт өвчин энэ бүсэд ч тэмцэж чадахгүй, тэр хэмжээгээр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тайлбар хийх хэрэгтэй. Мал эмнэлгийн лабораторийн чинь төсөв хэд дахин хасагдсан байна, хамгийн чухал зардлуудаа өөрсдөө хасаж хаягчаад, тэгээд өвчлөлтэйгөө тэмцэж чадахгүй, тэгсэн мөртөө тэнд ингээд лангуун дээр очих хэмжил зүйн ийм тоног төхөөрөмжийг авна гээд одоо өөр сайдын багц дээр сууж байгаа нь ер нь ямар ч уялдаа холбоо алга. Гэтэл өнөөдөр лаборатори дээр тавих вакцин худалдаж авах тэр хэмжээний төсөв чинь маш их хэмжээгээр хасагдаж, танагдсан байна гэдэг нэг асуулт гарч ирж байна.

2 дугаарт, тодруулга юуны, энэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр яг энэ 14.1 тэрбум төгрөгийг ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ гээд задаргааг.../минут дуусав/

Б.Заяабал: Мандхай гишүүний асуулт, тодруулга дээр холбогдох албан тушаалтнууд дэлгэрэнгүй хариултыг албан бичгээр өгөхөөр боллоо. Тэрэн дээрээ дэлгэрэнгүй өгөөрэй. Сангийн сайд Мэндсайхан сайдын микрофон өгье.

З.Мэндсайхан: Энэ Мандхай гишүүний асуугаад байгаа тоног төхөөрөмжүүд 2026 оны батлагдсан төсөв дотроо анхнаасаа байж байгаа. Ямар төсөвт юу нь яагаад хасагдсан бэ гэхээр, дүн нь яагаад хасагдсан бэ гэхээр тодотголтой холбоотойгоор гэрээ байгуулагдаагүй дүнгээрээ л бүгд хасагдаад явж байгаа юм. Түүнээс биш одоо эд нарын юун дээр нэмж тодотголоор ямар нэгэн тоног төхөөрөмж энд тэнд байгууллага дээр суулгасан асуудал байхгүй. Тодотголын зарчим бүгдийг нь гэрээ байгуулагдаагүй хөрөнгө оруулалтуудыг хасаад л оруулж ирж байгаа.

Б.Заяабал: Мандхай гишүүний тодруулга.

М.Мандхай: Тэгэхээр ингэсэн үг үү? Одоо, жишээлбэл мал эмнэлгийн ариутгалын зардлыг 353 аравны саяас 20 сая хүртэл буюу 94.5 хувиар хасчихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ улсын хэмжээнд 20 сая төгрөгөөр одоо бид ариутгал хийх гэж байгаа юм болов уу гээд тодруулаад асуучихъя. Тэгэхээр бид энэ шинэ омгийн шүлхий, гоц халдварт өвчинтэй тэмцэх гэж байгаа ийм нөхцөл байдалтай байх үед бид хэрхэн энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэх вэ? Гэрээ хийгдээгүйн улмаас одоо ингээд бид тэмцэж чадахгүй гэсэн үг юм уу? Энэ төсөв байхгүй тэмцэж чадахгүй болох уу гэдэг энэ асуултыг асууя.

2 дугаарт, энэ СЕХ-ны тоног төхөөрөмж гээд нэг ийм 41.7 тэрбум төгрөг байна, 26 онд нь 12.5 гэсэн байгаа юм байна. Тэгээд үндсэндээ ингээд би дахиад хэлэхэд Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн бараг 80 хувьтай тэнцэхүйц төсөв байна л даа. Тэгэхээр энэ өөрөө тэргүүлэх чиглэлийн хувьд хэрхэн үндэслэлтэй вэ гэдэг нэг асуултыг хариулаад.../минут дуусав/

Б.Заяабал: Мэндсайхан сайдын микрофон өгье, Сангийн яам.

З.Мэндсайхан: Би тэр хөрөнгө оруулалт яагаад хасагдсан бэ гэдэг дээр л танд хариулж байна даа. Түүнээс биш тэр малын ариутгал юуны ажил урсгал зардал дээр сайд нь өөрөө хариулах нь зөв байх, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас асууна.

СЕХ дээр төсөвт өртөг нь 41 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж тавигдсан байгаа. Ерөнхийлөгчийн сонгууль 2027 онд болно, тэрэнтэй холбоотойгоор бэлтгэл ажил хангах ажлууд байгаа. Энэ хүрээнд энэ онд 12 тэрбум, ирэх онд 29 тэрбумын саналын машин, бэлтгэл хангахтай холбоотой л зардлууд юм байгаа юм. Түүнээс биш СЕХ дээр энэ зардлыг хасаад сонгуулиа явуулахгүй байж болохгүй. Тэгэхээр бид тэр хүрээнд л тавьсан зардал байгаа байх.

Б.Заяабал: Баярлалаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам индрийн микрофон.

Г.Болорсүх: Яамнаас, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ гээд урсгал зардал дээр Сангийн яам руу нийтдээ 98.5 тэрбум төгрөгийн санал явуулсан. Сангийн яам хянаад 49.8 тэрбум болгон бууруулж хянаж өргөн барьсан байгаа. Энэ хөрөнгө оруулалт биш, дандаа урсгал зардал байгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, вакцины үнэ,

шинжилгээ, оношилгооны үнэ, мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардал, эрүүлжүүлэх зардал гэсэн ийм зардлууд дээр тусгагдсан зардал байгаа.

Б.Заяабал: Баатархүү гишүүний микрофон өгье.

Ц.Баатархүү: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Төсөв хэлэлцэхийг ч гурилддаг л болж байна. Шулуухан хэлэхэд энэ хариулж байгаа, асууж байгаа, тэгээд ингээд 2 жил ингээд л гурилдлаа. Гурилдаж байгаа учраас төсвийн тодотголыг өргөн барьж байна шүү дээ. Төсөв өөрөө тоогоор илэрхийлж байгаа хөгжлийн бодлого. Бид тоо бүрээр нь батлах шаардлага үүсэж байна, УИХ ингээд тойм баталчихаар маш олон асуудал эргэж үүсэж байна. Тэгэхээр манай Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо нэг зүйл дээр илүү их анхаарах ёстой, Сангийн яам өргөн барьж байгаа материалын чинь тэр дэлгэрэнгүй зүйл чинь алдаатай байна лээ, эксель /excel/ файл чинь алдаатай, бөөн хэрүүл. Бид одоо тооцоо хийж болдоггүй, шинжилгээ хийж болдоггүй, харьцуулж болдоггүй, зүгээр нэг ийм унших материал ингээд сканердаад /scan/ оруулчихсан л байдаг D-Parliament-д, энийг одоо манай бүлгээс санаачлаад өргөн барих гэж байгаа юм. Цаашдаа хэдүүлээ маш тодорхой явъя гэж байгаа юм.

Монгол Улс 2026 онд нүүрсээ хамгийн их зарж борлуулсан жил байна, 16 секундэд нэг вагон нүүрс гарч байна, нэг цагт 224 вагон нүүрсийг зарлаа. Монгол Улсын түүхэнд хамгийн их өвөг дээдсийнхээ үлдээсэн энэ байгалийн баялаг буюу нүүрсээ зөөж гаргасан жил байна, орлого хангалттай байна. Гэтэл төсвийн алдагдал чинь 2.2 их наядад байна. Энгийнээр дахин тайлбарлах юм бол аав нь хамгийн их цалин авсан жилээ тухайн айл өрх хамгийн их өрөнд орж байгаатай адилхан байна. Тэгээд Сангийн сайдаас би дахиад нэг зүйлийг асууя, иргэдэд Засгийн газар бүсээ чангал гэж хэлсэн. Иргэдэд чинь чангалах бүс алга, гэтэл Засгийн газар бүсээ бүрэн тайлчихлаа, өр зээлийнхээ өрийг нээсэн, одоо энэ төсвийн чинь тодотгол дээр өргөн барьсан материалд гадаадын өр зээлийг 5 дахин нэмэгдүүлбэл ийм санал орж ирж байна, энийг одоо яг тодорхой тайлбарлаач гэдгийг хүсэж байна?

2 дугаарт, тэтгэвэр, цалин нэмэхийг бүгдээрээ дэмжиж байна. Гэхдээ нэг логик байна, логикоор нь бодох юм бол азын сугалаанд мөнгө хожчихоод түүгээрээ байрныхаа түрээсийг төлж байгаатай адилхан байна. Уул уурхайн орлого гэдэг өөрөө дандаа тогтвортой байдаггүй. 1 удаагийн орлогоор байнга гарах энэ зардлыг санхүүжүүлэх логик яваад байна. Тэгэхээр цаашдаа бид нарын нэмж байгаа тэтгэврийн нэмэгдэл, цалингийн нэмэгдлийг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх юм бэ гэдгийг Сангийн сайд нэг тодорхой хариулж өгөөч гэж хүсэж байна?

3 дугаарт, яагаад урсгал зардлаа бууруулахгүй нэмж оруулж ирж байгаа юм бэ? Монгол Улсын Ерөнхий сайдын хэлж байгаа үг биелдэг байх ёстой, хүнгүй хотод төсөв тавихгүй гээд л ороод ирсэн. Гэтэл өнөөдөр хүндтэй хотоо мартаад, хүнгүй хот Хүннү, Хархорин хот дээр дахиад төсөв нэмээд ороод ирсэн. Бид нарын одоо энэ мэдээлэл, сурталчилгааны зардал гэж айхтар том төсөв байдаг юм байна энэ Засгийн газрын төсөв нь нэг сардаа 1.4 тэрбум төгрөгөөр рийл /reel/ хийдэг юм байна. Энэ томилолтын зардал гэж айхтар том зардал байдаг юм байна, сардаа 7 тэрбум төгрөгийн томилолтын зардал байдаг юм байна л даа, гэх мэтчилэн ингээд хэмнэх зардлуудаа бид огт хэмнэхгүй орж ирж байгаа чинь өөрөө төсвийн дэндүү сахилга батгүй байдал бий болгож байна. Бид ингээд нэг талдаа зөв юм яриад байдаг, тэтгэврээ нэмье, цалингаа нэмье гэдэг. Гэтэл Засгийн газрын өргөн барьж

байгаа урсгал зардлаа нэмж байгаа энэ байдал чинь энэ тэтгэврийн нэмэгдлийг чинь инфляцад.../минут дуусав/

Б.Заяабал: Сангийн сайдын микрофон нээе. Мэндсайхан сайдын микрофон.

3.Мэндсайхан: Төсөв батална гэж гурилдана гэж байгаа бол тэгээд л одоо та бид хоёр хоёулаа л гурилдаж байгаа байх. Яагаад гэхээр УИХ-аар хэлэлцээд, Их Хурал руу Засгийн газар төсвөө өргөн барьж байгаа, Их Хурал хэлэлцээд л баталж байгаа, ингэж хэтэрхий худлаа туйлширч болохгүй. УИХ-д Засгийн газар төсвөө өргөн барихдаа зардлын ангиллаар нь өргөн барьдаг юм, тэгээд эксель файл битгий нэх, тэр эксель файл чинь төлөвлөгөө надтай, тэр Сангийн яамны өргөж байгаа төсөв, төсвийн хуультай түй ч хамаа байхгүй. Эхлээд өөрөө та асуудлаа сайн задалж үз. Би Цэнгүүн гишүүний мэдэгдлийг харсан, тэр санаачлах гэж байгаа хууль маш зөв. Яагаад гэхээр төсөв батлагдсаны дараа төсвийн ерөнхийлөн захирагчид багцаа задалдаг, задлах нь тухайн сайдын эрх байдаг, тийм учраас энийг нээлттэй болгоё, энэ шийдвэр ямар үндэслэл дээр, тооцоолол дээр гарч байна гэдэг төсөв батлагдсаны дараах процесс. Түүнээс биш би эксель /excel/ файл татаж аваад тэрийг одоо Их Хуралд орж хэлэлцүүлж байсан, би болон миний өмнө тийм сайд байхгүй, тийм Төсвийн тухай хууль ч байхгүй.

Уул уурхайн орлого өндөр байна уу гэхээр уул уурхай өнөөдөр зэсийн үнэ өндөр байна, алт үнэтэй байна, нүүрс маань биет хэмжээгээрээ их гарч байна. Би тантай санал нэг байна. Гэхдээ энэ орлогууд, таны яриад байгаа төсөвт энэ уул уурхайн бүтээгдэхүүний огцом үнийн өсөлтийг бид орлогодоо урсгал зардалдаа аваад явах юм бол энэ үнэ савснаараа эргээд төсөв болон эдийн засагт хүчтэй шок /shock/ үзүүлнэ гэж үздэг. Тийм учраас тэнцвэржүүлсэн орлого буюу энэ орж ирж байгаа орлогууд чинь тэнцвэржүүлсэн орлого руу ордог юм. Бид өөрсдөө яаж орлогоо төлөвлөж байна гэхээр сүүлийн 12 жилийн дундаж өсөлтийг, уул уурхайн бүтээгдэхүүний өсөлтийг аваад явж байгаа.

Одоо бид оруулж ирж байгаа Тогтвортой байдлын санд өөрчлөлт оруулах хуулиараа уул уурхайн бүтээгдэхүүний өсөлтийг хасаад, бусад салбарын ДНБ-ий өсөлтийн хэмжээгээр зардлаа тэлнэ гэдэг бодлого чинь орж ирж байгаа. Ингэж бид уул уурхайн огцом өсөлтөөс энэ төсвийг хамгаалж явж байгаа. Уул уурхайн тогтворгүй орлогоор урсгал зардлыг санхүүжүүлэх гээд байна гэж байна, өнөөдөр бид Төсвийн бүтцийн бүрэлдэхүүнээ харах юм уул уурхайн орлого чинь 30 хувийг нь төсвийн орлого талаа бүрдүүлээд явж байгаа. Ингэж хамаагүй замбараагүй ярьж болохгүй, бид орлого маань эндээс явж байгаа шүү дээ. Ихэнх уул уурхайн орлого чинь Ирээдүйн өв сан руу орж байгаа байхгүй юу. Тэр огцом өсөлтийн зөрүү чинь, тэрийг бид төсөв дээрээ тусгахгүй хамгаалж явж байгаа байхгүй юу. Тэгж байж энэ эдийн засаг, түүнээс биш алтны үнэ өсөнгүүт нь тэрийг бид барьж аваад л зарлага руугаа шилжүүлээд байх юм бол таны хэлж байгаа эрсдэл үүснэ. Энийг чинь бид Төсвийн тогтвортой байдлын тэр батлаад байгаа тэнцлээрээ бид чинь хангаад явдаг байхгүй юу. Төсөв хийж байгаа зарчим энэ шүү дээ. Ямар нэгэн байдлаар Өрийн удирдлагын хуулиар өр нэмсэн асуудал, тэр 5 дахин нэмсэн асуудал.../минут дуусав/

Б.Заяабал: Цогтбаатар гишүүний микрофоныг өгье, нэмэлт, Мэндсайхан гишүүн нэмэлт юм уу.

3.Мэндсайхан: Гадаад зээл 5 дахин өсөж байгаа асуудал байхгүй. Өнөөдөр гадаад зээлийн хэмжээ Төсвийн тогтвортой байдлын, Өрийн удирдлагын хуулиараа ДНБ-ний 60 хувьтай тэнцэх ёстой. Та бидний баталсан төсвийн хүрээгээрээ 50 хувь хүрэх ёстой. Энэ тодотголоор нэмээд 40 хувьтай, төсвийн тодотгол хийгээд, та 27 оны төсөв ороод ирэхээр бас хараарай. Бүх өрийн болон гадаад зээлийн таазаа хангаад явж байгаа. Энэ 20 дахин өссөн, 5 дахин өссөн юм хаана ч байхгүй.

Б.Заяабал: Баатархүү гишүүний микрофон, нэмэлт тодруулга.

Ц.Баатархүү: Төсвийн 2026 оны тодотголынхоо материалыг Мэндсайхан сайд гүйцэд уншсан болов уу л гэж хэлмээр байна. Энд одоо таны ярьж байгаа зүйл биелдэг бол Монгол Улсад инфляц ийм өндөр байхгүй, иргэдийн орлого, бодит орлого 4.9 хувиар агшихгүй, аж ахуйн нэгжийн бодит орлого 33 хувиар агшихгүй. Тэгэхээр зээл авах эрхээ 562 тэрбумаас 2.7 их наяд болгоод 5 дахин өсгөөд оруулаад ирсэн.

2 дугаарт, цаашдаа бид энэ тэтгэврийн нэмэгдэл, багш нарын цалингийн нэмэгдлийг яг ямар эх үүсвэрээс бид санхүүжүүлэх вэ гэдэг дээрээ 27, 28 оныхоо тоймыг хариулаад өгөөч. Энд одоо цэцэрхэх биш, маш тоотой, тооцоотой нэг хариулт өгөөч гэж хүсэж байна.

Б.Заяабал: Мэндсайхан сайдын микрофон нээе.

3.Мэндсайхан: Цэцэрхэж байгаа юм огт байхгүй. Бид хаврын чуулганаар нийгмийн даатгал болон татварын багц хуулийг баталсан, Баатархүү гишүүнээ, энэ дээр тэтгэврийн багц хуулиараа бид шинэчлэлээ хийгээд явж байна. Энэ дээр 2.4 их наядын өнгөрсөн оныхоос зардал нэмэгдэж байгаа юм, татварынхаар 2.8 нэмэгдэж байгаа, гэхдээ 28 оныг хасах юм бол 2,2. Бусад нийгмийн даатгалын хуулийн тэр зохицуулалт болон татварын хуулийн үйлчлэлээр нийтдээ энэ жил хуульчлагдсан зардал 5.7 их наядаар нэмэгдэж байгаа. Энэ зардлуудыг бид хууль хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг, төсөвтөө бид шингээж оруулж ирж байгаа. Гэхдээ төрийн өмчит компаниудын улсын төсвөөс гадуур явж байгаа тэр ногдол ашгаар хийгдэж байгаа буюу цэвэр ашгаас хийгдэж байгаа асуудлыг бид оруулж ирж байгаа болохоос компанийн үйл ажиллагаанд оролцоод, тэрний орлого.../минут дуусав/

Б.Заяабал: Хариултаа гүйцээе, Мэндсайхан сайдын микрофон өгье.

3.Мэндсайхан: Баялгийн сангийн хууль гарсантай, одоо жишээлбэл Эрдэнэс Монгол дээр Монгол Улсын Засгийн газарт өгөх ёстой ногдол ашгийн хэмжээ 7.4 болно энэ оны эцэс гэхэд, одоогийн байдлаар 5.2 их наядыг өгөх ёстой. Эрдэнэс Монголын баланс /balance/ дээр 3.4 их наядын цэвэр ашиг байна. Энэ мөнгийг төсвийн гадуур эдийн засаг руу ороод байна, тэгэхээр энийг, мөн хавар баталсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар чинь 27 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлээд төрийн өмчит компаниуд 30-аас доошгүй хувийн ногдол ашгийг өгөх ёстой болчихсон. Энэ гарцуудыг чинь нээж бид нэгдсэн төсөвтөө явъя, тэр төсвийн гадуур яваад байгаа орлогуудаа төсөвтөө аваад явъя л гэдэг зарчмаар оруулж байгаа юм. Энүүгээр бид иргэддээ ногдол ашгаараа дамжуулж, урсгал зардал, хөрөнгө оруулалтаараа дамжуулж иргэддээ хүрэх ёстой тэр бодлогынхоо хүрээнд л оруулж ирж байгаа юм.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга, Баатархүү гишүүний микрофон.

Ц.Баатархүү: Ер нь бид ингээд зөв зүйлээ нөгөө гараараа одоо ирээдүйг нь устгах, үнэгүйдүүлэх ажлыг л хийгээд байна, Засгийн газар. Юу юм бэ гэхээр одоо нэг жоохон нэмж байгаа энэ тэтгэврийн нэмэгдэл, цалингийн нэмэгдлээ Засгийн газрын өргөн барьж байгаа хуулиар урсгал зардлаа нэмээд байх юм бол зээлийн хүү чинь өндөр болно, инфляц чинь дахиад өснө. Ингээд бид нарын нэмэгдүүлж байгаа энэ мөнгийг үнэгүйдэх гээд байна. Одоо өнөөдөр тэтгэврийн нэмэгдэл чинь тийм ч их нэмэгдэл биш, 5-аас 6 килограмм махны мөнгө болчихоод байна шүү дээ. Энийг бид ингээд зөв болгохгүй бол энэ гараараа зөв юм яриад, нөгөө гараараа устгах бодлогыг яагаад оруулж ирээд байгаа юм бэ гэдэг асуудлыг хөндөж байгаа юм.

2 дугаарт, энэ Эдийн засаг, хөгжлийн яам яагаад Байнгын хорооныхоо хурал дээр сайд нь ирдэггүй юм бэ, ингээд мэргэжилтнүүд явуулж байна. Тийм учраас манай Байнгын хороо энэ дээр хариуцлагатай баймаар байна гэдгийг дахин хэлье. Баярлалаа.

Б.Заяабал: Санал хэллээ. Цогтбаатар гишүүний микрофон өгье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хоёр ирж оролцож байгаа. Төсвийн тодотголоо ярьж байгаа учраас энэ хоёр байгууллагаас, дээрээс нь нэмээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс иргэдийн асуугаад байгаа асуултыг асуух гэсэн юм. 1 дүгээрт, энэ иргэдийн нуруун дээр байгаа өр зээлийн дарамтын асуудал маш ихээр ихсэж байгаа, тэр дундаа аппликейшний /application/ зээлийн асуудал маш ихээр явагдаж байгаа, өрнөөс өрийн хооронд амьдарч байгаа чанаргүй зээл 7 дугаар сарын байдлаар харахад дахиад өсөөд байгаа, 2.5 хувиар өсчихсөн байгаа. Энэ дээр та хоёр хамтарч байгаад аппликейшний зээлийг цэгцлэх талаас нь арга хэмжээ авахгүй бол иргэд улам бүр өрөнд дарагдаад яваад байдаг. Энд манай сайд, дарга нарын яриад байгаа том том тоо өрхийн хаалгаар ороод, иргэдэд ерөөсөө бодит байдал дээрээ наалдахгүй байгаа. Энэ тал дээр та хоёр ямар дорвитой арга хэмжээ авч ажиллах вэ гэж нэг асуулт, өөрсдийнхөө саналыг хэлээч?

2 дугаарт, энэ хар жагсаалттай холбоотой асуудал байгаа юм. Яах вэ, иргэд яг ингээд өөрсдийн хариуцлагагүй байдлаасаа болоод нэг удаа алдсан байж болно. 2, 3 давтан алдсаныг бол өршөөе гэж байгаа юм биш. Гэхдээ иргэд нэг удаа санамсаргүй байдлаар үүрэн телефоны оператораас нэг утас лизингдсэн юм уу, СӨХ төлбөрийн хугацаа хоцроосон асуудал ч юм уу ингээд асуудал үүсчихсэн байгаа асуудал дээр нь нэг удаа тэр хар жагсаалтад байгаа хүмүүсийг, тэр дундаа залуучуудыг эсвэл бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг зөв ангилалд нь шилжүүлэх энэ ажлыг хийж эхлүүлэх хэрэгтэй байгаа. Энэ дээр би 6 сард Монголбанкнаас дата /data/ авч байсан, энэ дээрээ хамтарч ажиллах ажлыг эхлүүлэх шаардлагатай байгаа учраас шаардлагатай хүмүүсээ томилоод, УИХ-ын тогтоолын төсөл батлах ажлын хэсгийг танай хоёр байгууллага хамтарч гаргадаг бол энийг гаргаж өгч ажиллах хэрэгтэй байна.

3 дугаарт, энэ Оюу Толгойн ногдол ашгийг иргэдэд өгнө, эсвэл бүтээн байгуулалтад нь ашиглана, эсвэл уул уурхайн компаниудаас оруулж ирж байгаа энэ өгөөжийг хувьцаат хэлбэрээр иргэдэд амь оруулж өгнө гэж янзын их тайлбар яваад

байгаа юм. Яг иргэд бодитой, зөв мэдээлэл авч чадахгүй байгаа. Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эрдэнэс Монгол, Чингис хаан баялгийн сангууд яг иргэдэд энгийн үгээр, мэргэжлийн гадаад нэр томьёо ашиглахгүйгээр иргэдэд зөв мэдээллийг нэг өгөөч гэж хүсэх гэсэн юм.

4 дүгээрт болохоор, одоо яг жишээлэхэд өнөөдөр манай өрөөнд Баянхонгор аймгийн нэг сумын Засаг дарга орж ирээд хүсэж байна. Төсвийн тодотгол дээр, эсвэл төсөв дээр гишүүдэд Оюу Толгойн ногдол ашгаас 6 тэрбум төгрөг өгөөд байна гэнэ, энэ 6 тэрбум төгрөг дотроо манай сумын энэ асуудлыг шийдээд өгөөч гээд орж ирээд байгаа юм. Ямар нэгэн байдлаар албан ёсоор надад 6 тэрбумын эрх үүсгэсэн асуудал бол байхгүй. Сангийн сайд энэ дээр нэг тодорхой тайлбар, албан ёсны хариу хэлэх байх. Гишүүдэд 6 тэрбум төгрөгийн Оюу Толгойн ногдол ашигтай холбоотой эрх үүсгэсэн, нээсэн асуудал байхгүй гэдгийг албан ёсоор хэлэхгүй бол сумын дарга нар чинь та нарын өмнөөс бидэнд мөнгө өгөөд, тэгээд бид тэрийг нь улсын төсөв дээр харамлаад байгаа юм шиг ийм буруу ойлголт яваад байгаа учраас энэ Оюу Толгойтой холбоотой та нар зөв зөвшилцөлд хүрч байгаа бол тэрийгээ ямар арга замаар, яаж иргэдэд хүртээх юм, яаж санал асуух юм гэдгээ зөв тайлбарлаад өгөөч гэсэн ийм 4 хүсэлт, асуулт байна.

Б.Заяабал: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хариулъя. Сангийн сайд Мэндсайханы микрофоныг өгье.

3.Мэндсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Оюу Толгойтой Засгийн газар хэлцэл хийсэн хавар, хэлцлийн үр дүн гарсан. Сая өнгөрсөн долоо хоногт хэлцлээр гарсан үр дүнг Хувь нийлүүлэгчдийн гэрээнд өөрчлөлт оруулж бид баталгаажууллаа. Энүүгээр ногдол ашиг өгөхөөр болсон. 26 оны тайлан, балансаа гүйцэтгэлээрээ 27 онд ногдол ашгаа хуваарилъя, ингэхдээ Засгийн газар, мэдээж 27 оны төсвийг төсөвлөхдөө ногдол ашгаас орж ирж байгаа тодорхой зүйлийг ирээдүйд бид эдийн засгаа тэлэх, инфляцын өсөлтөд хамгийн их хүчтэй нөлөөлж байгаа дэд бүтцийн буюу эрчим хүчний салбарт зориулъя гэдэг ийм хөрөнгө оруулалтын төслийг 27 онд оруулж ирсэн. Энэ дээр ямар нэгэн гишүүдэд квот хэм хэмжээ өгөөгүй, Засгийн газар нэн тэргүүний ээлжид бидний хувьд хамгийн том тулгамдаж байгаа салбар юу вэ, эрчим хүчний салбар байна. Дутагдаж байгаа хэрэглээ, иргэдийн маань амьдралд болон эдийн засгийн өсөлтөд хамгийн их дарамт болж байгаа салбар бол эрчим хүчний салбар байна. Энэ салбараа бүрэн шинэчлээд авъя. Ногдол ашгийнхаа хамгийн анхны орж ирж байгаа ногдол ашгаасаа тодорхой хэсгийг нь иргэддээ өгье, тодорхой хэсгийг нь хөрөнгө оруулалт болгоё, энэ дээр ямар нэгэн гишүүдэд өгсөн тэдийг, эдийг Оюу Толгой дээр орж ирэх ногдол ашгаас ингэнэ, тэгнэ гэсэн асуудал байхгүй гэдгийг хариуцлагатай хэлье.

Б.Заяабал: Индрийн микрофон, Монголбанкны Ерөнхийлөгч.

С.Наранцогт: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Системийн хувьд чанаргүй зээл 5.3, тэгэхдээ таны хэлж байгаа тэр аппликейшний зээл дээр өсөлт гараад чанаргүйдэж байгаа асуудал бодитой. Тэгээд энэ хоёр шалтгаантай бий болсон. 1 дүгээрт, энэ зээлийн мэдээллийн сан өөрөө гар аргаар 3 хоногийн дараа зээл авсан мэдээлэл ордог ийм байсан. Тийм учраас би ажил аваад манайх энэ дээр бодит цагийн горимд шилжүүлэх тэр JSON protocol гэдэг зүйлээр энэ мэдээллийн санг сайжруулах ажил хийгээд банкнууд бүгдээрээ орсон. Жамбаажамц дарга үргэлжлүүлээд хариулах байх. Банк, санхүүгийн байгууллагууд бүгд орох ёстой. Ингэж байж мэдээлэл бодитой авах учраас яг бодитой зээл авах гэж байна

уу, эсвэл ингээд аппликейшн ажиллуулж байгаа 3, 4 банкнаас зэрэг авчхаад санаатай төлөхгүйгээр авсан тийм тохиолдлууд нэлээд байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ дээр ийм ажил хийгдэнэ, 9 сард бол ер нь энэ бүх санхүүгийн байгууллагуудыг.../минут дуусав/

Б.Заяабал: Индрийн микрофонд нэмэлт нэг минут өгье.

С.Наранцогт: Энэ ажлыг ийм зорилт тавиад ажиллаж байна. 2 дугаарт, таны хэлээд байгаа тэр мэдээллийг сайжруулах асуудал маш чухал байгаад байгаа юм. Энэ ямар асуудал үүсэх гээд байна вэ гэхээр ингээд нэг удаа хөшиг татаад өмнө нь муу зээлийн түүхийг нь ерөөсөө харуулахгүй болгочихсон юм байна лээ 24 онд, ингэнгүүт нөгөө ялгаж, ялгавартай хандах ёстой асуудлыг нийтэд нь аваад нөгөө муу зээл аваад төлдөггүй хүмүүс дахиж зээл авах боломжийг бий болгосон. Тэгэхээр таны тэр ажлын хэсэг дээр би өнөөдрөөс хүмүүс томилж байгаа. Тэгэхээр энийг нарийвчлаад үнэхээр аль нь боломжийн юм, тэгээд аль нь үнэхээр давтан зээл авчхаад төлөхгүй, хэрэв тийм боломж гарвал дахиж тийм муу зээл үүсгэх ийм хандлага үүсгээд байгаа юм бэ гэдэг дээр бид нухацтай ажиллах нь зайлшгүй байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр бол энэ зээлийн мэдээллийн санг сайжруулах, аппликейшн хүнээс хамаарахгүй өөрөө зээлийн мэдээллийн санд боловсруулалт хийгээд, оноог аваад өгдөг учраас.../минут дуусав/

Б.Заяабал: Санхүүгийн зохицуулах хороо.

Т.Жамбаажамц: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Аппликейшний зээл өөрөө хэрэглээний зээл байдаг, хэрэглээний зээл учраас Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оноос яг энэ аппликейшний зээл дээр хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг тогтоож мөрдүүлж явж байгаа. Ялангуяа Монголбанкны энэ макро зохистой бодлого, мөнгөний бодлогынхоо бодлоготой нийцүүлж Санхүүгийн зохицуулах хорооноос энэ өр, орлогын харьцааг, ялангуяа хэрэглээний зээл дээрх өр, орлогын харьцааг тогтоож, сүүлийн жил гаруйн хугацаанд 2 удаа өр, орлогын харьцааг 60/40 болгоод, сая он гараад 1 дүгээр сарын 20-нд 55/45 байхаар тогтоогоод ингээд явж байгаа. Өөрөөр хэлбэл, хэрэглээний зээл дээрх өр, орлогын харьцааг нэлээн чангаруулж байгаа. Нөгөө талаас хэрэглээний зээл сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн салбар дээр жилд дунджаар 42.3 хувиар өсөж байсан. Өнгөрсөн 25 оны.../минут дуусав/

Б.Заяабал: Индрийн микрофоныг нээе, нэг минутаар нэмж өгье.

Т.Жамбаажамц: 2025 оны 3 дугаар сард сая миний дурдсан бодлогын шийдвэрүүд гарснаас хойш хэрэглээний зээл анх удаа тогтворжсон байж байгаа. Нөгөө талаас хэрэглээний зээл дээр ялангуяа энэ зээлийн давхардлууд асар их байгаад байгаа юм. Хэрэглээний зээлийг гол хянаж байгаа функц зээлийн мэдээллийн сан байж байгаа. Зээлийн мэдээллийн сан дээр иргэдийн авч байгаа зээлийн мэдээллийн давхардал, зээлийн давхардал аппликейшнууд дээр асар их байсан, үүнийг Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк зээлийн мэдээллийн сан дээр холбогдох тохируулгууд хийгээд, сая Төв банкны Ерөнхийлөгчийн шинэ систем энэ жилээс ажиллаж эхэлсэн. Нийтдээ финтекийн /fintech/ үйлчилгээ үзүүлдэг 82 нэр бүхий ББСБ бүрэн энэ зээлийн мэдээллийн санд реал тайм-аар /real-time/ мэдээллээ нийлүүлдэг болсон. Тэгэхээр өөрөөр хэлбэл, мэдээлэл тухай бүрдээ нийлүүлэгдэж байгаа учраас яг энэ өөрчлөлтүүд хэрэглээний зээлийн давхардал харьцангуй багассан гэж хэлж болж байна.

Б.Заяабал: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулъя, дараа нь Үндэсний баялгийн сангийнхан бэлдэж байгаарай. Индрийн микрофон өгье.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат, Цогтбаатар гишүүний асуултад товчхон хариулъя. Тэгэхээр энэ төсвийн тодотголоор Тогтворжуулалтын сангийн орлого 367.7 тэрбум төгрөгөөс 826.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээд, нийтдээ 459.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Үндэсний баялгийн сангийн орлого 2.9 их наядаас 3.4 их наяд буюу 459.3 тэрбумаар нэмэгдэж байгаа. Иймээс тодотголоор нэмэгдсэн энэ нийт орлогын хэмжээ бүхэлдээ төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлт биш, байгалийн баялгийн орлогыг сангуудад хуримтлуулж байгаа нэмэгдэл гэж ойлгох хэрэгтэй. Гэхдээ байгалийн баялгийн орлогын тодорхой хэсгийг төсвийн урсгал зардалд ашиглахгүйгээр хуримтлуулж, өөрөөр хэлбэл түрүүн хэлсэн Тогтворжуулалтын сан болон Хуримтлалын санд хуримтлуулж байгаа нь эерэг үзүүлэлт байгаа гэж бид харж байгаа. Ер нь гэхдээ.../минут дуусав/

Б.Заяабал: Нэмэлт нэг минут өгье.

А.Энхбат: Цаашдаа энэ уул уурхайн салбараас бий болсон нэмэлт ашиг, төрийн өмчит компаниудын ногдол ашгийг бид төсвийн урсгал зардал, өөр цалин, тэтгэвэр, тэтгэмжид зарцуулахаасаа илүү хөрөнгө оруулалтын шинж чанартай, эдийн засагт нэмүү өртөг бий болгох ийм төсөл, хөтөлбөрүүдэд ашиглах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Төсвийн одоогийн нөхцөл байдлаар болохоор төсвийн татварын орлого гэхээсээ илүү татварын бус орлого ингээд нэмэгдээд явж байгаа нь бид цаашдаа төсвийн тогтвортой татварын орлогыг байнга байлгах хэрэгтэй гэсэн үзэл баримтлалтай байж байгаа. Баярлалаа.

Б.Заяабал: Чингис хаан баялгийн сан нэгдэл компанийн гүйцэтгэх захирал Даваадалай, индрийн микрофон нээе.

Б.Даваадалай: Чингис хаан баялгийн сан нэгдлийн хувьд эхний хагас жилд 9 их наядын борлуулалт хийсэн байна, 1.6 их наядын ашигтай ажилласан байна. Ер нь төрийн өмчит компаниуд ачааллаа үүрч ирсэн, энэ удаа ч гэсэн төсөв хүндрэлтэй, орлого бага үед дэмжлэгээ үзүүлээд явах гэж байна. Бид азтай нь зэсийн үнэ өндөр байна, өнөөдрийн байдлаар 14400 байна, нүүрсний үнэ 66 орчим байна. Ер нь өнгөрсөн жилтэй харьцуулахад харьцангуй гайгүй. Тодотгол дээр 1 их наядын дэмжлэг үзүүлэх гэж байгаа юм. Ер нь Баялгийн сангийн тухай хуулиараа бид төрийн өмчит компани 100 төгрөгийн ногдол ашиг хуваарилбал тэрнийхээ 34 хувийг Баялгийн санд, 66 хувийг нь төрд өгөх ёстой, төрд өгөх ногдол ашгийн өглөг нэлээн өндөр байгаа. Энэ бол Тавантолгой дээр одоогийн байдлаар 5.8 их наядын өглөг байгаа. Энэ өглөгөөсөө тооцож 1 их наядын өглөгийг төсөвт, хэрвээ хуульд өөрчлөлт оруулах юм бол дэмжлэг үзүүлье.../минут дуусав/

Б.Заяабал: Индрийн микрофонд нэг минутаар сунгая.

Б.Даваадалай: 2-т нь, иргэдэд яаж хүрч байгаа юм бэ гэхээр, Баялгийн сангаараа дамжуулж Баялгийн сангийн хууль баталснаас хойш 1.7 их наяд төгрөгийн, 34 хувьд ногдох ногдол ашиг хуваарилсан байна. Одоогоор нэг иргэнд ногдох нэрийн дансанд байгаа үлдэгдэл 306 мянган төгрөг байгаа, энийг оны эцэст 480 мянган төгрөг хүргэхээр ажиллаж байгаа. Үндсэндээ энэ онд 550 орчим тэрбум

төгрөгийг оруулна гэж төсөвлөж байгаа. Нэмээд нэг зүйлийг иргэдэд гэж хандаж гишүүн асуусан учраас, 1072 хувьцааны асуудал яригдаж байгаа. Ирэх оны төсөвт Үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт ороод, Жамбаажамц дарга илүү хариулах байх, 2 дахь зах зээл дээр 1072 хувьцаа бүртгэлийг нь хийе гэж байгаа. Эрдэнэс Тавантолгой компани дээр олон улсын аудит орсон BDO, удахгүй үр дүнг нь гаргана, үнэлгээ хийгдэнэ. Анх гарч байхдаа 12 онд иргэдэд эзэмшүүлж байхдаа 933 төгрөгийн үнэлгээтэй байсан юм байна лээ, одоо энийг зах зээл дээр үнэлгээг нь хийнэ. Хэрвээ боломжтой бол ирэх оны дундуур гэхэд.../минут дуусав/

Б.Заяабал: Баярлалаа. Цэнгүүн гишүүний микрофоныг нээе.

С.Цэнгүүн: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Ер нь энэ төсвийн тодотголыг нэлээн нягталж харсан. Тэгээд Аудитын газраас яг энэ 26 оны төсвийн тодотгол дээр албан ёсны дүгнэлттэй, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бууруулж, урсгал зардлыг дахин тэлж нэмэгдүүлсэн нь урт болон дунд хугацаанд төсвийн болон үнийн тогтвортой байдлыг хадгалахад эрсдэл үүсгэж байна гэдэг дүгнэлтийг Аудитын газраас гаргасан байгаа юм. Тэгээд нягтлаад хараад үзэхээр яалт ч үгүй урсгал зардлаа бид шаардлагагүйгээр тэлчихсэн нь үнэн л байна л даа. Одоо энэ Хархорум хотын Захирагчийн ажлын алба гээд 26 ондоо болохоор 4.1 тэрбум төгрөгийг бид төсөвлөөд явж байгаа юм. Тэгтэл төсвийн тодотголоороо цоо шинээр Хархорум хотын зөвлөлийн ажлын алба гээд 1.5 тэрбумыг нэмээд ороод ирсэн. Тэгээд энэ чинь одоо нөгөө “100 ямаанд 60 ухна” гэдэг шиг, байхгүй хот дээр бид 4.1 тэрбум төгрөгийн ажлын алба угаасаа ажиллаж байгаа юм. Тэгээд байж байхад ахиад зөвлөл гэж тусад нь байгуулаад, 1.5 тэрбумыг гаргах яг ямар зайлшгүй шаардлага байгаа вэ гэдгийг асуумаар байна. Энэ чинь одоо бид тодорхой захиргааны албаа, зардлаа багасгая гэдэг л саналтай уг нь яваад байдаг, гэтэл ийм байдлаар нэмэгдүүлсэн байна.

Нөгөө талдаа нэг зүйл байгаа нь болохоороо, ер нь 2025 оны аудитын дүгнэлтээс энэ төслийн нэгжүүд, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийг татан буулгая гээд 25 төсөл хэрэгжүүлэгч нэгжийг татан буулгасан байгаа юм. Тэгтэл өнөөдөр 26 оны төсвийн тодотголоор ахиад 14 яам, тэгээд нийслэл дээр нэмэх нь 15 төсөл хэрэгжүүлэх нэгжийг ахиад шинээр байгуулж байна. Эндээ болохоор нийтдээ 8.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар байгаа юм. Гэтэл 2025 онд үүссэн асуудал нь юу вэ гэхээр, энэ төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд нь менежментийн зардалтай гээд баахан техник, тоног төхөөрөмжүүд аваад, хотын А бүсийн дээд зэрэглэлийн оффисуудад 10-аас 25 сая төгрөгийн оффис түрээсэлж суугаад, тэгээд гүйцэтгэл нь болохоор 7 хувь ч хүрэхгүй гүйцэтгэлтэй байж, одоо жишээ нь энэ тээврийн холболт, логистикийн /logistics/ төсөл нь болохоор 7.1 хувийн гүйцэтгэлтэй, тэгээд 2025 онд болохоор 3.4 тэрбум төгрөг авчихсан байж байгаа юм. Тэгэхээр энэ төслийн нэгжүүд чинь ерөөсөө үр ашигтай ажиллаж чадахгүй байна шүү дээ гээд Аудитын дүгнэлтээрээ бид 2026 ондоо төслийн нэгжүүд шинээр байгуулахгүй гээд явчихсан байж одоо тодотголоороо 8.4 тэрбум төгрөгөөр нэмээд оруулж ирж байгаа нь жоохон учир дутагдалтай юм болов уу гэж хараад байгаа юм.

Тэгээд үндсэндээ төсөл хэрэгжүүлэх нэгжүүд маань магадгүй нөгөө нэг гаднын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд дээр зайлшгүй гэрээтэй холбоотойгоор хийгдэж байгаа гэж Сангийн сайд тайлбар өгөх байх л даа. Гэхдээ энэ хүмүүс чинь төслийн нэгжид ажиллаж байгаа хүмүүс нь яаманд ажиллаж байгаа хүмүүсээсээ 3-аас 5 дахин өндөр цалинтай байдаг. Тэгээд бид чинь уг нь яамандаа өндөр чадамжтай тийм мэргэжилтнүүдээ бэлдье гээд ингэж авдаг хэр нь нөгөө

талдаа болохоор ингээд тэр хүмүүсийгээ чадавхжуулах ажил биш, нэг төслийн нэгж гэдэг энэ зүйлээр орон тоог нь нэмэгдүүлээд байгаа гэж харагдаад байна. Тэгэхээр энэ чинь 2025 онд жишээ нь 46 төслийн нэгжийг буулгахад 250 хүний орон тоо бид хэмнэж чадсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ буцаагаад ингээд зах замбараагүйгээр баахан төслийн нэгж гэдэг нэрээр менежментийн зардлаа нэмэгдүүлээд байх нь буруу харагдаж байгаа.

Тэгээд ерөнхийдөө төсвийн тодотгол дээр ч тэр, одоо 27 оны улсын төсөв ярих гэж байхад ч гэсэн бид нэг ийм задаргаагаа харддаг баймаар байна. Ер нь улсаараа нийтийн төсвөө ажигладаг баймаар байна гэдгийг санаачилж байгаа. Тэгээд тэр агуулгаараа бид бүхэн нам харгалзахгүйгээр нийтдээ нээлттэй төсөвтэй болъё, онлайн /online/ дээр бүх задаргаагаа харуулдаг болчихъё гэдгийг санаачлаад явж байгаа, маш олон УИХ-ын гишүүд дэмжиж байгаад нь маш их талархалтай байгаа гэдгээ энэ ташрамд хэлъе.

Б.Заяабал: Сангийн яам, дараа нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нэмэх үү? Сангийн сайдын микрофон өгье, Мэндсайхан сайдын микрофон.

3.Мэндсайхан: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Тэр Хархорум зөвлөлийн зардал нэмэгдсэн гэдэг асуудал, ер төсвийн тодотголоор ямар ч зардал нэмэгдээгүй. Яагаад нэмэгдсэн юм шиг харагдаад байна гэхээр, Хэрэг эрхлэхийн сайд дээр Хархорум хотын төсөв бүхэлдээ суучихсан, зөвлөл маань 26 оны энэ төсөв батлагдахад байгуулагдсан юм байна лээ Их Хурал дээрээс тогтоолоор. Ингээд төсвийг нь салгаад өгсөн тийм л асуудал байгаа. Хэрэг эрхлэхийн сайд дээр суусан багцаас зөвлөлийнх нь багцыг нь салгаж өгсөн. Тэгэхээр нийт дүнгээрээ зөвлөл дээр шинэ зардал гарч ирээгүй, зардал маань төсвийн ерөнхийлөн захирагчийнх нь багцад суучихсан явж байсан гэсэн үг.

Тэр төсөл, хөтөлбөртэй холбоотой зардал дээр, яам болгон дээр хэрэгжиж байгаа энэ төслүүдийг нэгтгээд бид нэгдсэн төсөвтэй болгоод явж байгаа. Тэр нь өөрөө нэгдсэн төслийн нэгж гэж байгуулаад 470 орчим хүнтэй байсан бол одоо 210 болоод явж байгаа. Төслийн цалин мөнгөний асуудал тухайн төслийн өөрийнх нь буцалтгүй тусламж, төслийн нэгжээсээ өөрөө цалинжаад явдаг, эндээс төсөвт ямар нэгэн цалин хөлс өгч байгаа асуудал байхгүй мэргэжилтнүүдэд. Тухайн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой олгож байгаа эх үүсвэрээр нь санхүүжүүлээд явдаг ийм л тогтолцоотой. Энэ дээр мэдээж бид салбарын чадвартай хүмүүсээ алдана, ийшээ шилжүүлнэ гэхээсээ илүүтэй энэ дээрээ харин бид хүмүүсээ бэлдэж авах шатлал болгож явж байгаа. Ер нь цаашдаа мэдээж энэ асуудлыг хумиад явах нь зөв байх, илүү боловсронгуй болгоод энэ төслийн нэмэлт урсгал зардлуудыг хянах тал дээр нь. Гэхдээ энэ тухайн төсөл, хөтөлбөрийнхөө эх үүсвэрээр санхүүжээд явдаг, тодотгол дээр ямар нэгэн улсын төсөв дээр зардал нэмж ингэж орж ирсэн асуудал байхгүй.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүн нэмэлт.

С.Цэнгүүн: Тодотгол дээр яг нөгөө нэг нэмж байгаа хэлбэрээр ороод бичигдээд явчихсан байна л даа, тийм болохоор асуугаад байгаа юм. Энэ чинь одоо нэг бичиглэлийн алдаа гэж та хэлэх үү? Одоо тодотгол дээр нэмэлтээр явчихсан байгаа болохоор зарчмын зөрүүтэй санал гаргаад, энэ чинь нэмэлтээр явж байгаа учраас бидэнд УИХ-ын гишүүдэд хасах эрх нь байж байгаа. Тэр утгаараа бид

зарчмын зөрүүтэй саналаар энэ мөнгийг хасах боломжтой юм байна, тийм үү? Төслийн нэгж аль аль нь шинээр, тодотгол дээр шинээр мөнгө тусгагдсан байгаа юм л даа, 8.4 тэрбум төгрөг 15 төслийн нэгж дээр нэмэлтээр байна. Хархорум хотын зөвлөлийн ажлын алба гээд 1.5 тэрбум төгрөг нэмэлтээр орж ирсэн байна.

Б.Заяабал: Сангийн сайдын микрофоныг нээе. Мэндсайхан сайдын микрофон.

З.Мэндсайхан: Хархорум нь би хэллээ шүү дээ, ямар нэгэн нэмэлтээр орж ирж байгаа биш, хасаж болохгүй, хасах юм бол наадах чинь тэгээд тэр зөвлөл чинь юугүй болчхож байна л гэсэн үг, цалин хөлсгүй болчхож байна л гэсэн үг. Батлагдахад нь Их Хурал дээр батлагдахад нь төсвийн ерөнхийлөн захирагч буюу Хэрэг эрхлэхийн сайдын багцад нь тусгаад, зөвлөл байгуулахыг нь Их Хурлын тогтоолоор зөвшөөрчихсөн юм байна лээ. Тэгээд одоо зөвлөлийн нэгж нь байгуулагдаад явахаар тэр сайдын багцад суусан урсгал зардалд нь санхүүжүүлээд явж байгаа ийм л хэлбэр байгаа, тэрийг нь бид салгачихсан л гэсэн үг ангиллаар нь. Төслийн юуг нь Дэлгэржаргал дарга нэмээд хариулчих уу.

Б.Заяабал: Индрийн микрофон Цэнгүүн гишүүний асуултад тодорхой нэмэлт хариулт өгье. Индрийн микрофон нээе.

Ж.Дэлгэржаргал: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Дэлгэржаргал. Тэгэхээр гадаад зээл тусламжийн төслүүд дээр Сангийн сайдын хэлсэнчлэн өмнө нь 46 төслийн нэгж байсан. Нэгдсэн төслийн нэгжийн тогтолцоонд шилжүүлээд, төсөл болгон төслийн нэгжтэй байсан нь одоо салбар дээр нэг төслийн нэгж явж байгаа. Тэгэхээр төсөл өөрөө яг 2-оос 3 жилийн хугацаатай хэрэгждэг, хөлсөөр ажиллах гэрээтэй 210 гаруй хүн байгаа. Яг энэ үйл ажиллагаатай холбоотой ихэнх нь тусламжийн болон зээлийн эх үүсвэрээр санхүүжихээр, зүгээр тооцооллынхоо хавсралт дээр өмнө нь бүх л дүнгээрээ явдгийг задалж оруулсантай холбоотой шинээр нэмэгдсэн юм шиг харагдаж байгаа. Тэгэхээс урсгал болон төслийн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой зардал тодотголоор ямар нэгэн хэмжээгээр нэмэгдэх асуудал байхгүй, байсан бүхэл дүнгээрээ байгаа.

Б.Заяабал: Пунсалмаа гишүүний микрофоныг нээе.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Эмч, багш, төрийн албан хаагчдын цалин хөлсийг өсгөж байгаа, ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж байгаа энэ зүйлийг бол дэмжиж байна. Үүний цаана 200 гаруй мянган аж ахуйн нэгж, сая гаруй хувийн хэвшлийн салбарт ажиллаж байгаа иргэдээ яаж дэмжих гэж байна вэ? Энэ төсвийн тодотголын төсөв дээр энэ хувийн хэвшлүүдийг дэмжих ямар бодлого байна вэ? Хувийн хэвшлийг дэмжих ерөөсөө гол үндсэн хөшүүрэг бол бага хүүтэй зээл байхгүй юу. Арилжааны банкны бага хүүтэй зээл. Өнөөдөр Монгол Улсад арилжааны банкны зээл 15-аас 20 хувь байна. Гэтэл хөрш оронд чинь жилийн хүү нь 4 хувь гэж байна шүү дээ. Ерөөсөө энд чинь л үйлдвэрлэл, хөгжлийн чинь гол ялгаа, энэ арилжааны банкны зээлийн асар өндөр түвшин чинь байхгүй юу. Өнөөдөр энэ төрийн өмчийн компаниудын өндөр зардал, энэ төсвийн өөрөө энэ өндөр зардал энэ чинь өөрөө инфляцыг маш өндөр хөөрөгдөж байгаа шүү дээ. Тэгээд энэнийх нь горьыг нь яагаад аж ахуйн нэгжүүд үүрэх ёстой юм, яагаад аж ахуйн нэгжүүдэд бага хүүтэй зээл олдохгүй байгаа юм бэ?

Өнөөдөр аж ахуйн нэгжүүд чинь муудчихаад байгаа учраас өнөөдөр төсөв тасарсан шүү дээ, импортын орлого, онцгой. Энэ компаниуд чинь татвараа төлж чадахгүй болж байгаа байхгүй юу. Тэгэхээр манай энэ мөнгөний бодлого, энэ Эдийн засаг, хөгжлийн яам макро эдийн засгийн түвшинд энийгээ яаж Засгийн газрын бодлоготойгоо уялдуулж энэ шийдлийг гаргах юм бэ? Бид энэ арилжааны банкнуудынхаа хүүг л буруулахгүй бол манай эдийн засаг ерөөсөө хөгжихгүй байна, энэ ерөөсөө эдийн засгийн гол хамгийн боомилж байгаа асуудал чинь энд байгаа. Тэгэхээр энэ талаар та нарын саналыг сонсьё.

Б.Заяабал: Сангийн яам, дараа нь Эдийн засаг, хөгжлийн яам хариулъя, Сангийн сайдын микрофон өгье.

З.Мэндсайхан: Эдийн засгийн өсөлтөө харах юм бол уул уурхайгаас бусад салбар өсөлтгүй байна, тэгэхээр бусад салбаруудын идэвхжилийг дэмжих шаардлагатай байна гэдэг нь эндээс харагдаж байгаа. Ер нь хамгийн том ажил олгогч салбар хөдөө аж ахуйн салбар, худалдаа, боловсруулах салбарууд байгаа. Тэгэхээр энэ салбарууд дээр ажил эрхлэлтийн түвшин буурч байгаа. Нөгөө талдаа хамгийн өсөлтгүй салбар барилгын салбар сүүлийн 2 жил царцсан байдалтай байгаа. Тэгэхээр Засгийн газар 27 оны төсөв дээрээ хувийн хэвшлийг дамжуулан олон улсын зах зээл дээрээс эх үүсвэр босгоод, энэнийхээ свопын зардлыг нь төсөвтөө авах замаар бага үүсвэртэй зээл гаргах, нөгөө талдаа бага хүүтэй ипотекийн бодлогыг хэрэгжүүлэх энэ 2 хөтөлбөрийг оруулж ирж байгаа, 27 оны төсөв хэлэлцээд явахаар илүү тодорхой болох байх.

Юу вэ гэхээр зэрэг, Төрийн банкаар дамжуулаад нэг жилийн 10 хувийн хүүтэй, хамгийн их инфляцад идэгдээд байгаа тэр үйлчилгээний салбар, иргэдийнхээ бичил бизнес эрхлэгчдээ дэмжих зорилгоор жилийн 10 хувийн хүүтэй аж ахуйн нэгжид 300 сая, иргэдэд 100 орчим сая төгрөгийн зээл олгох тэр 1.1 их наядын ийм нийт зээлийн хэмжээтэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж гэж Засгийн газар 27 оны төсвийн төсөл дээр оруулж ирсэн байгаа. Нөгөө талдаа орон сууцны зах зээл маань нийлүүлэлт тал нь ингээд царцчихсан байна, тэгэхээр эрэлт талаа дэмжье, ипотекийн бодлого дээрээ эхний 3 жил 6 хувийн хүүтэй, 4 дэх жилээс 12 хувийн хүүтэй ийм ипотекийн багц бүтээгдэхүүнийг оруулахаар, энийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар зөвхөн свопын зардлыг нь төсөвтөө аваад явж байгаа, ингэж төсөвлөж оруулж ирсэн байгаа.

Б.Заяабал: Эдийн засаг, хөгжлийн яамнаас, индрийн микрофон дээр.

Б.Мөнх-Эрдэнэ: Бодлогын хувьд 2 зүйл байгаа, Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах энэ бодлогоо тууштай хадгалаад явна гэж харж байгаа Засгийн газрын хувьд. Бодит тооны хувьд бол төсвийн нийт зардлын эдийн засагт эзлэх хувь 35 хувь, төрийн өмчит компаниудын зардлын эдийн засагт эзлэх хувь 25 хувь, ер бодитоор эдийн засагт эзлэх хувь 61 орчим хувьтай байгаа. Тэгэхээр 1 дүгээрт, энэ төрийн өмчит компаниудын ногдол ашгуудыг төсөв дээрээ авчирч бичиж байна гэдэг нь бид харин чиг нэг балансаар энэ төрийн эдийн засаг дахь эзлэх оролцоог нэг дүрмээр явуулж байна гэж харж байгаа. 2 дугаарт, төсвийн хүрээний мэдэгдэл дээр эдийн засаг дахь төсвийн нийт зардлын хэмжээг жил бүр бууруулах бодлогыг төлөвлөж байгаа. 3 дугаарт, зээлийн үнийн тухайд инфляц, ханш.../минут дусав/

Б.Заяабал: Индрийн микрофоныг нэг минутаар нэмье.

Б.Мөнх-Эрдэнэ: Инфляц, ханш бид 4 жилийн өмнө бол манай нийт инфляцын бараг 60, 70 хувь нь ханшийн уналтаас үүдсэн, валютын нөөцийн бууралтаас үүдсэн ийм шалтгаантай байсан. Тэгээд Засгийн газрын тухайд сүүлийн 3, 4 жил экспортын орлогоо тогтмол нэмэгдүүлэх, ялангуяа валютын экспортын орлогыг бодитойгоор оруулж ирэхэд шат дараатай арга хэмжээнүүд авсан, боомтын сайжруулалтуудыг хийсэн, худалдааны бодлого хэрэгжүүлсэн, нөгөө хил үнэ, уурхайн амны үнэ, уул уурхайн биржийн тогтолцоо гээд энэ засгаас хийсэн ажлуудын үр дүнд, мэргэжлийн хувийн хэвشلүүдийн үр дүнд одоо нүүрсний экспорт маань тухайлбал 20, 30 сая тонн байсан бол одоо 100 сая тоннд хүрээд байна.

2 дугаар зүйл, инфляц маань маш эмзэг зүйл, гэхдээ Засгийн газрын зүгээс нийлүүлэлтийн гаралтай инфляц дээр яг холбогдох инфляц өсдөг саруудад тохируулгуудыг хийж явах ёстой л гэж харж байна.

Б.Заяабал: Пунсалмаа гишүүний тодруулга, нэмэлт өгье.

Б.Пунсалмаа: Инфляц бууруулах ийм бодит алхмуудыг энэ тодотголоос харахгүй байгаа юм л даа. Түүгээр ч барахгүй инфляцыг илүү хөөрөгдөх нэмэлт зардал гаргаад байгаа юм. Тэгээд энэнээсээ бодлогын хүүгээ бууруулах талаар ерөөсөө шийдэл гаргаж ирэхгүй байна. Тэгэхээр одоо бид энэ Засгийн газрын шийдвэр, энэ Төв банкны бодлого хоёроо нэгтгээд бодлогын хүүгээ хүчээр бууруулах хэрэгтэй. Бид олон жил энэ бодлогын хүүг өндөр байлгасан, инфляц буураагүй улам л өсөж байна. Бодлогын хүүгээ өндөр байлгана гэдэг өөрөө инфляц буулгах арга биш юм байна. Тэгэхээр бид энийг одоо реформ хийж өөрчлөх хэрэгтэй байна, энийг Эдийн засаг, хөгжлийн яам анхаарч ажиллаасай.

Б.Заяабал: Пунсалмаа гишүүн санал хэллээ. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Одоо төсвийн тодотголтой холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа, Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ төсвийн тодотгол яагаад хийх болов гэдэг энэ шалтгаан, үндэслэлүүдээ нэлээн сайн судлах шаардлагатай байна гэж харж байгаа. Өнөөдрийн макро эдийн засгийн нөхцөл байдалтай судалгаа, шинжилгээг Эдийн засаг, хөгжлийн яам, бусад байгууллагууд хийж байгаа. Гэхдээ яг оношоо яг зөв тавиад тэр чиглэлээр ажлаа яг хийж байна уу гэдэг дээр асуулт байгаад байгаа юм. Өнөөдөр ингээд хараад үзэхээр иргэд ч тэр, аж ахуйн нэгжүүд ч тэр аль аль нь өрийн дарамтад нэлээн хүнд байдалд орчхоод байна. Үүнтэй холбоотойгоор эргүүлээд уул уурхайгаас бусад салбарын борлуулалтын орлого, уул уурхайн бус салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувийн жин.../үг тасрав/

Б.Заяабал: Ажлын хэсгийнхэн сууж байгаарай.

Л.Соронзонболд: Тийм учраас энэ талаар ер нь Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам цаашдаа энэ төсвийн бодлого, энэ эдийн засгийн бодлогоо гаргахдаа нэлээн сайн анхаарах шаардлагатай байна гэж үзэж байна.

Б.Заяабал: Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Төсвийн тодотголтой холбоотой үндсэн суурь зарчмуудыг дэмжиж байгаа. Үүсээд байгаа цаг үеийн нөхцөл байдал, эдийн засгийн, нийгмийн, улс орнуудын геополитикийн /geopolitical/ нөхцөл байдалд өнөөдөр бид ямар

нөхцөлд амьдралд амьдарч байгаа вэ, иргэдийн амьдрал ямар байгаа вэ, төрийн албан хаагчдын цалин хөлс, энэ бизнес эрхлэгчдийн орчин ямар байна вэ гэдэгтээ би бодит үнэлэлт, дүгнэлт өгөөд харин ч энэ инфляцад өртөж байгаа хэсгийн цалин хөлсийг нь нэмэгдүүлж бодлого бариад ороод ирлээ гэж харж байгаа. Ахмадуудыг өнгөрсөн жилийн турш л бид жагсаасан, 1.5 саяд тэтгэврээ хүргэе л гээд олон сар жагссан. Тэгээд өнөөдөр болоод байгаа учраас, хүрэлцээд байгаа одоо цалин хөлс дээр жагсаал цуглаан хийгээд байгаа юм ерөөсөө байхгүй байгаа шүү дээ, асуудал гацаад байгаа юм ерөөсөө байхгүй.

Боловсролын салбар, эрүүл мэндийн салбарын хувьд үүссэн тэр цалингийн зөрүүг арилгах, ингэхдээ масс нь хүний тоогоороо боловсрол, эрүүл мэндийн салбар эзэлж байгаа ч гэлээ гэсэн нөгөө талдаа яг энэ цалингийн өсөлтөөр инфляцад нэрвэгдчихээд байгаа соёл, спорт, урлагийнхны цалин хөлс, төрийн албан хаагчдын, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс нэмэх хэрэгцээ шаардлага байна уу гэвэл байна. Тэтгэврийн нэмэгдлийн хувьд ч ялгаагүй, бид хууль тогтоомжоо баталчихсан, нийгмийн сегмент /segment/ болгонд хүрсэн ийм төсвийн тодотгол орж ирлээ гэж харж байгаа. Мэдээж гишүүдийн хэлж байгаа зүйлийг, саналыг авч үзэх ёстой, мэдээж энэ дээр ажлын хэсэг гараад ажиллах байх, засаж сайжруулаад явахад болохгүй зүйл байхгүй гэж харж байгаа.

Инфляц хөөрөгдөх талаар нэлээдгүй асуудлууд хөндөгдөөд байгаа юм. Тэгээд энэ дээр би мэргэжлийн байгууллагууд ялангуяа Сангийн яам үүнд дүгнэлт хийж байгаа Үндэсний аудит, Монголбанк, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл аль аль нь дүгнэлт дээрээ яг нэг тодорхой тооцоо судалгаа гаргаад ирээсэй гэж харж байсан. Аль алинд нь харагдахгүй л байгаа юм. ТӨК-удын ногдол ашиг 66 хувь Эрдэнэс Монгол, хуучны Эрдэнэс Монгол, Чингис хаан баялгийн сан дээр ногдол ашиг хэлбэрээр тэнд төсөл хөтөлбөрт зарцуулах гэж байгаа мөнгө эдийн засаг дээр байгаа л мөнгө байхгүй юу. Мөнгө нэмж үйлдвэрлээгүй шүү дээ. Мөнгө нэмж хэвлээгүй байхгүй юу. Тэр нь урсгал зардал руу очихоороо инфляц өдөөнө л гээд байгаа юм. Харин ч том төсөл хөтөлбөр болоод валютаар тоног төхөөрөмж худалдаж аваад явсан бол гадагшаагаа л урсах байх. Нөгөө ханшийн зөрөөндөө бид улам л нэрвэгдэх байсан байх.

Цалин хөлс тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл болоод энэ чинь одоо иргэдийн өдөр тутмын хэрэглээнийхээ хоол хүнсийг авах л эдийн засгийн эргэлтдээ л нэмэр болж байгаа орж байгаа мөнгө гэж харж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ үнэхээр яг энэ хоорондын зөрөөнд инфляцын нөлөө байгаад байгаа юм уу, ноогдол ашиг хэлбэрээрээ байгаад хөрөнгө оруулалтад зарцуулахад ямар хэмжээний нөлөөтэй байсан юм. Урсгал зардал болоод ороод ирэхээр ямар хэмжээний нөлөө үзүүлээд байгаа юм. Тоотой баримттай судалгаатай бол гишүүдийн асуугаад байгаа эргэлзээ энэ зүйлийг тайлах боломж байх болов уу гэж би харж байгаа юм. Тэгэхээр энэ тооцоо судалгаа аль алиных нь дүгнэлт дээр л байхгүй байгаа. Одоо ер нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт ч гэсэн, Үндэсний аудитын газрын хийж байгаа дүгнэлт ч гэсэн нэг л тийм тунхаглалын шинжтэй болчихжээ. Мэргэжлийн байгууллагын хувьд мэргэжлийн дүгнэлт гаргадаг байгаач, тоо баримт дээр үндэслээч, судалгаагаа танилцуулаач, гишүүдийн асууж байгаа асуултад судалгаагаар хариулдаг болооч. Бид улс төрчдийн дүгнэлт сонсож байгаа юм шиг л нэг ийм ерөнхий дүгнэлтүүд орж ирдэг болчихсон нь энэ эргэлзээтэй олон зүйлүүдийг бий болгоод байна. Сангийн яам ч гэсэн анхнаасаа энэ өргөн барьж байгаа төсөв дээр санхүү эдийн засгийнх нь агуулгын хувьд өргөн хүрээнд анализ

хийж, тооцоо баримттайгаа танилцуулдаг байх нь зүйтэй гэсэн саналыг хэлж байна. Ингээд энэ төсвийн төслийг бол дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэбат: Яах вэ төсвийн тодотгол дээр яах аргагүй иргэдийн бодит орлогуудыг нэмэгдүүлэх чиглэлээр тэр тусмаа нийгмийн хамгийн эмзэг хэсгүүд рүү чиглэсэн тодотгол байгаа учраас би дэмжээд байгаа юм. Ялангуяа энэ инфляц өсчихнө гээд яриад байх шиг байна. Тодорхой хэмжээний нөлөөлөл байна. Хамгийн сүүлд би мэдээлэл авахад Монгол банкнаас 0,5-аас 0,7 одоо нэгж пунктийн нөлөөлөл үзүүлнэ гэдгээ хэлчихсэн. Тэгэхээр өнөөдрийн байдлаар инфляц 12 хувьтай, талаас илүүг нь мах, хүнсний ногооноос шалтгаалсан. Тэгэхээр бид цаашдаа иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх энэ асуудлыг ярихаар инфляц өсөж байна гэдэг нэрийдлийн дор ингээд хойш нь суугаад л байдаг. Тэгээд манай яг аваад үзэхэд амьжиргааных нь өртгийг аваад үзвэл тухайлбал махыг аваад үзэхэд чинь энэ чинь одоо хөгжингүй орнууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 10 дахин өндөр байдаг оронтой тэнцүү хэмжээний мах л авч идэж байна шүү дээ бид чинь. Тэтгэврийг нь аваад үзвэл бараг 10 дахин илүү тэтгэвэр авдаг орнуудын хүнс барааг л одоо иргэд худалдаж авч л байна. Зээлээс зээлийн хооронд л амьдарч байна л даа.

Тийм учраас би энэ төсвийн орлогыг зайлшгүй хийх ёстой. Эргээд энэ иргэд маань худалдаж авсан бараа бүтээгдэхүүн маань компани ААНБ-д орлого болж орж ирнэ. Ажлын байр болж орж ирнэ, эргээд татвар болж орж ирнэ гэдэг ийм л зүйлийг би хараад байгаа юм. Тийм учраас яах вэ энэ тал дээр яах вэ тэр анхааруулж байгаа, хэлж байгаа саналууд нь зүйтэй. Тэр дотроо тэр махны, хүнсний, цахилгааны үнийг одоо ингээд нэмэх хэрвээ энэ тодотголыг хийхгүй бол цахилгааны дулааны үнийг нэмэх болчихно. Тэгэхээр бүх ААН байгууллагуудад бүүр их том дарамт авчрах юм болов уу гэж бодож байгаа юм. Инфляцыг бүүр цааш нь өдөөх болов уу гэж бодож байгаа юм. Тийм учраас өрхийн чинь зарлагад эзэлж байгаа хувийг аваад үзэхээр манайхан нийтдээ ингээд зарлагынх нь хувийг аваад үзэхээр зээлийн хүүд ихэнх нь явдаг юм байна. Моргейжийн зээл ч ялгаа байхгүй. Одоо тэгээд моргейжийн зээл ч олдохоо байсан, орон сууцад орохын тулд жилийн 20 хувийн хүүтэй зээлийг авч л моргейжийн зээл нэг орон сууцтай болъё л гэдэг л залуучууд байна. Тийм учраас энэ зээлийн хүүд анхаарах ёстой гээд түрүүний гишүүдийн хэлдэг саналтай санал нэг байна. Аппликэйшний зээл гээд байж байна, ББСБ-ын эзэлж байгаа энэний чинь эзэлж байгаа зах зээлийнх нь хэмжээ тэлээд байгаа чинь л ерөөсөө иргэд орлого нь хүрэлцэхгүй зээлээс зээлийн хооронд амьдарч байна, илүү их зээлийн хүүгийн зардалд нь дарлуулж байна л гэж харж байгаа юм.

2 дугаарт тэр хөрөнгө оруулалт гээд байдаг хөрөнгө оруулалтыг хийхдээ учиртай хиймээр байгаа юм. Тэр инфляцыг өдөөдөг гадаадын асар их худалдан авалт хийдэг цаасан дээрх компаниуд яг ний нуугүй хэлэхэд бараа бүтээгдэхүүнүүдийг оруулж ирж зардаг, нэмүү өртөг бий болгодоггүй, ажлын байр шингээдэггүй ийм хөрөнгө оруулалтууд байгаа. Манайхан хөрөнгө оруулалт орж л байвал одоо юу ч байсан хамаа байхгүй сайн л гэдэг. Тендерийнхээ хуулийг өөрчилмөөр байна, хамгийн эхэнд инфляцын буюу эдийн засгийн юунд хүндрэлтэй байгаа ЖДҮ-лэлүүд чинь томоохон худалдан авалтын юунд орж чаддаггүй иймэрхүү л байдалтай одоо хүртэл байгаад байгаа шүү дээ. Тендерийн хууль болоод жил

болж байгаа. Тэгэхээр энэ тал дээрээ яаралтай энэ хуулиудаа өргөн бариад хиймээр байна гэж хэлмээр байна.

Урсгал тэнцлийн хувьд би дахиад л нэг хэлээд байна. Нийгмийн даатгал ЭМД-ын санг төсвийн мөнгө гэж оруулж ирээд, урсгал тэнцэл дотор оруулж ирээд ингээд байгаад байгаа чинь урсгал зардал болж харагдаад, тэгээд аягүй өндөр түвшин рүү авч ирж болж харагдаад ингээд энэ мөнхийн сэдэв болоод байгаа юм. Тэгээд энийгээ нэг яах ийхээ эдийн засагчид байна, мөнгөний бодлогынхон байж байна, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань нэг ярихгүй бол энэ дуусахгүй. Нийгмийн даатгалын сан руу чинь орж ирж байгаа мөнгө. Харин одоо энэ төсвөөс өгөх гээд байгаа суурь тэтгэвэр гэдэг зүйл чинь харин тэр урсгал буюу тэр урсгал зардал дотор чинь орох нь зөв. Өөрөө өөрийгөө орлогоороо зарлагаа нөхөөд явж байгаа тэр сангуудыг чинь төсөвт нэгтгээд байгаа чинь ерөөсөө дуусдаггүй яриа. Урсгал зардал маш өндөр байгаа мэт харагдаад л явуулаад байгаа. Тэгээд энийгээ нэг цэгцэлбэл яасан юм бэ гэдэг саналыг.../минут дуусав/

Б.Заяабал: Баярлалаа. Батнайрамдал гишүүний микрофон өгье.

О.Батнайрамдал: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр яах вэ 2026 онуудын төсвийн тодотголоос өгсүүлээд бид бараг 36 жил байгаагүй томоохон Сангийн яам ялангуяа Эдийн засаг, хөгжлийн яамныхан сонсоорой. Physical framework буюу төсвийн нийт бүтцийнхээ хэмжээнд нэлээн том өөрчлөлт оруулж байна шүү дээ. Сая Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга гэсэн тийм ээ, Мөнх-Эрдэнэ, бас л мундаг statement хэлж байна шүү. ТӨК-удынхаа ноогдол ашгийг төсөв рүү татахаар төсвийн бодлогоо одоо улам сайжруулаад олон улсын түвшин рүү аваачиж байгаа юм шиг л ярьж байна. Та одоо макро эдийн засгаар бараг л доктор хамгаалсан хүн байлгүй дээ, доктортой байх тийм ээ? Нэг удаагийн ноогдол ашгаар урсгал зардал санхүүжүүлээд төсвөө сайжруулдаг тийм жишиг мэдэх үү? Яах вэ улс төрч сайд нар ярихаар ойлгоод байна л даа. Гэхдээ одоо ингээд Макро эдийн засгийн бодлогын газрын дарга ингээд яриад байхаар ерөөсөө юу гэж бодохоо мэдэхгүй л байна даа.

Яах вэ өнөөдөртөө тэгээд л хүнд нөхцөл байдлаа бид ТӨК-ийн ноогдол ашгаар санхүүжүүлээд л явна л даа, одоо гарцгүй. Гэхдээ мэргэжлийн хүмүүс нь битгий ингэж яриач, жоохон наадхаа зөв тайлбарла. Ноогдол ашиг гэдэг чинь төлөх албатай ч мөнгө биш шүү дээ тийм биз дээ, мэдэж байгаа шүү дээ бүгдээрээ. Энэ чинь эдийн засгийн байдлаасаа тэр компани ашигтай ажиллахгүйгээсээ хамаараад ТУЗ нь төлөх, төлөхгүй албатай бас биш шүү дээ. Тэгэхээр тэрийг жил болгон дахин, дахин инфляцаар өдөөгдөж гардаг урсгал зардлаа санхүүжүүлэхээр тэр макро эдийн засгийн бодлогын хувьд зөв шийдэл юм уу? Би таныг одоо яг энэ асуулт дээр чинь яг жилийн дараа дахиад хариулт авна шүү. Тэр үед нөхцөл байдал юу болчихсон байх нь тэгээд хоёулаа дахиад энэ дээр нэг хариулах хэрэгтэй болно.

Дээрээс нь ЗГ энэ төсөв өргөн барихдаа хэдэн том төсвөөсөө том үндсэн чиглэлийн хуулиа өөрчилдөг боллоо. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа нэмэлт, өөрчлөлт оруулна. Үндэсний баялгийн сангийн хуулиа дагалдаж өөрчлөлт оруулна. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль гэдэг чинь ганц удаагийн төсвөөр өөрчлөгддөг жижигхэн хууль биш байхгүй юу. Энэ чинь жинхэнэ таны яриад байдаг макро эдийн засгийн хувьд, Монгол Улсын макро эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой нэг удаагийн төсөв битгий хэл, таван жилийн бодлогоор өөрчлөгдөх үү, үгүй юу гэдгийг шийддэг

ийм том хуулиуд байхгүй юу. Гэтэл нэг төсвийн зүгээр нэг 3-хан сар үлдсэн нэмэлт, өөрчлөлтөөр ийм том хуулиа ингээд өөрчилж болж байгаа юм уу? Даваадалай дарга бас сууж байх шиг байна. Яах вэ Үндсэн хуулийн, Үндэсний баялгийн сангийн 10.12-г өөрчлөөд ингээд ногдол ашгийг улсын төсөв рүү макро эдийн засгийн зөв бодлого гээд татъя л даа. Тэгэхээр одоо гадаадын менежментэд өгнө гэсэн тэр Блэк Рок /BlackRock/, Франклин Темплтон /Franklin Templeton/ яах юм бэ? Reinvestment ноогдол ашиг тавихгүйгээр дахин санхүүжүүлээд Growth period буюу өсөлт дээрээ явж байгаа компаниудаа томруулж тэрнээс эдийн засгийн үнэлгээгээ сайжруулаад тэрнээсээ ашгаа авдаг ийм л менежмент байхгүй юу.

Тэгэхээр чинь тэд чинь төсөв чинь ноогдол ашгийг нь бүгдийг нь ховх сорчихоор энэ үндсэн том компаниуд чинь тэгвэл хөгжих ямар ч боломж олгохгүй нь байна шүү дээ. Тэгээд ийм компаниуд дээр гадаадын тэр менежерүүд орж ирэх юм уу? Тэд нь энийгээ мэдэж байгаа юм болов уу? Тэгэхээр нэг иймэрхүү бодлогын хэмжээний том өөрчлөлтийг нэг үндсэн Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчилмөөргүй л байгаа юм л даа.

Б.Заяабал: Гишүүд үгээ хэлж дууслаа. Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа. Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

13.01 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА